

Судалгааны ажлын цуврал

МОНГОЛ УЛС

**Хүүхдийн мөнгөний хөтөлбөр, түүнд хамрагдагсдыг
тодорхойлох аргачлал**

Судалгааны ажлын дугаар 2006-1

М. Каридад Араухо

**Дэлхийн Банк
Вашингтон Д. С. АНУ**

2006 оны 4 дүгээр сар

МӨНГӨНИЙ ХАНШ

(2006 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн ханш)

Мөнгөний нэгж 1 Монгол төгрөг = 0.008926 ам. доллар

1 ам. доллар = 1120.37 төгрөг

САНХҮҮГИЙН ЖИЛ: 1 ДҮГЭЭР САРЫН 1-НЭЭС 12 ДУГААР САРЫН 31

ТОВЧИЛСОН ҮГ, ХЭЛЛЭГ

| | |
|-------|--|
| БМБШ | Бэлэн мөнгөний болзолт шилжүүлэг |
| ХМХ | Хүүхдийн мөнгөний хөтөлбөр |
| МУЗГ | Монгол Улсын Засгийн газар |
| ӨАЕМС | Өрхийн амьжиргааны ерөнхий мэдээллийн судалгаа |
| МИД | Малын индексжүүлсэн даатгал |
| ОУВС | Олон улсын валютын сан |
| АТС | Амьжиргааны түвшний судалгаа |
| НХХЯ | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам |
| ЯЭК | Ядуурлын эрсдлийн коэффициент |
| ТХТ | Тогтвортой хөгжлийн төсөл |
| УБ | Улаанбаатар |
| НҮБХХ | Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр |
| ДБ | Дэлхийн банк |

Энэхүү баримт бичгийг Дэлхийн банкны Зүүн Ази, Номхон далайн Хүний хөгжлийн асуудал хариуцсан багаас эрхлэн гаргасан болно. Тус тайлантай холбоотой аливаа санал сэтгэгдэл, асуултыг caraujo@worldbank.org имэйл хаягаар Каридад Араход илгээнэ үү. Судалгааны багийн зүгээс Монгол Улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны ажилтнуудын оруулсан хувь нэмэр, уулзалт ярилцлагуудад талархал илэрхийлэхийн зэрэгцээ энэ тайланг боловсруулах явцад мэдээллээр хангасан Азийн хөгжлийн банк болон НҮБХХ-ийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Гарчиг

| | |
|---|----|
| Гарчиг..... | 2 |
| Оршил..... | 3 |
| 1. Удиртгал: Монгол улсын нийгмийн халамжийн салбар ба Хүүхдийн мөнгөний хөтөлбөр 3 | |
| Хүүхдийн мөнгөний хөтөлбөр..... | 4 |
| Монголын нийгмийн халамжийн салбар дахь Дэлхийн банкны туслалцаа | 6 |
| Энэ салбар дахь бусад хандивлагчдын оролцоо | 7 |
| 2. Аймгийн түвшинд ХМХ-т хамрагдсан байдал, амьжиргааны зөрөө | 7 |
| 3. Загварчлах арга барилд тулгуурласан хөтөлбөрийн хамрах хүрээг тодорхойлох томъёоны үнэлгээ | 11 |
| Хамрагдагсдын тоо | 14 |
| Хүснэгт 2 Хөтөлбөрт хамрагдагсдын тоог аргачлал тус бүрээр урьдчилан таамагласан байдал..... | 15 |
| Өрхүүдийн ангилал ба хөтөлбөрийн боловсруулалтын үр нөлөө | 15 |
| 4. Зөвлөмжүүд | 19 |
| Хөтөлбөрт хамрагдагсдыг тодорхойлох томъёог боловсронгуй болгох | 19 |
| ХМХ-ийн төлөвлөлт, хэрэгжилтийг боловсронгуй болгох..... | 20 |
| <i>Хавсралт 1: ХМХ Засаг захиргааны тоо баримт болон 2000 оны тооллогын хувьсагчид</i> 23 | |
| <i>Хавсралт 2: ЯЭК-ын загварчлалд орсон хувьсагчид</i> | 24 |
| <i>Хавсралт 3: Хөтөлбөрт хамрагдагсдыг тодорхойлох томъёог хялбарчлах нь– жишээ ..</i> 27 | |
| <i>Хавсралт 4: Мексикт хэрэгжүүлсэн “Oportunidades” хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргагсдаас цуглуулсан мэдээлэл (эдгээр хувьсагчдаас хэрэглээг хамгийн сайн илэрхийлж чадах үзүүлэлтүүдийг сонгосон)</i> | 29 |
| <i>Ном зүй</i> | 30 |
| <i>Дэлхийн банкны Зүүн Ази, Номхон далайн Хүний хөгжлийн асуудлаархи багаас эрхлэн гаргасан судалгааны ажлын цуврал</i> | 31 |
| Зураг 1 ХМХ-ийн хамрах хүрээ ба хүн амын боловсролгүй хэсэг | 8 |
| Зураг 2 ХМХ-ийн хамрах хүрээ ба хөдөөгийн хүн ам | 9 |
| Зураг 3 ХМХ-ийн хамрах хүрээ болон цэвэр шилжилт хөдөлгөөн | 10 |
| Зураг 4 12-р сараас 6-р сар хүртэлх хугацааны хөтөлбөрийн өсөлт болон гэр бүлийн дундаж хэмжээ..... | 11 |
| Зураг 5 Хөтөлбөрт хамрагдагсдыг тодорхойлох аргуудыг өрхүүд хэрхэн ангилсныг харьцуулсан байдал | 17 |
| Зураг 6 С1 Хэрэглээний загварт үндэслэн ядуу болон нэн ядуу өрхүүдийг буруу тогтоосон байдал..... | 18 |
| Хүснэгт 1 Хөтбөрт хамрагдасдыг тодорхойлох нэмэлт аргууд..... | 14 |
| Хүснэгт 2 Хөтөлбөрт хамрагдагсдын тоог аргачлал тус бүрээр урьдчилан таамагласан байдал..... | 15 |
| Хүснэгт 3 Хөтөлбөрийн боловсруулалтын алдаа (Хамгийн ядуу, 146,000 хүүхэдтэй өрх) | 18 |
| Хүснэгт 4 Хөтөлбөрт хамруулах, үл хамруулах ажилд гарсан алдаа (Хамгийн ядуу 146,000 хүүхэдтэй өрх) | 19 |

Оршил

Монголын нийгмийн халамжийн тогтолцоо өөрчлөгдөн шинэчлэгдэж байна. 2003 онд баталсан салбарын Мастер төлөвлөгөө нь нийгмийн халамжийн тэтгэлгийг илүү зөв чиглүүлж, оновчтой болгох шаардлага байгааг тодорхойлсон. Үүнтэй уялдан Хүүхдийн мөнгөний хөтөлбөрийг 2005 онд хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү хөтөлбөрийг боловсруулах явцад хамрах хүрээг нь тогтоохын тулд төлөөлүүлэх жиших шинэлэг аргыг хэрэглэсэн. ХМХ нь орон даяар нэг жилийн хугацаанд хэрэгжиж, улсын хэмжээнд хамгийн том нийгмийн халамжийн хөтөлбөр болж өргөжсөн. Хөтөлбөр хэрэгжиж эхлэхээс өмнө туршилт хийгдээгүй учир хөтөлбөрийн төлөвлөлт болон хэрэгжилтийг сайжруулахад шаардлагатай зүйлсийг тодруулах нь чухал байна.

Энэхүү тайланг ХМХ-тэй холбоотой бодлогын шинж чанартай яриа хэлэлцээнд хувь нэмэр оруулах зорилгоор боловсруулсан бөгөөд ХМХ-ийн хамрах хүрээ хурдтай өргөжиж байгаа нь түүний санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй гэж санаа зовох хүмүүс их байна. Энэхүү тайлан нь ХМХ-ийн хамрах хүрээг судлах замаар ядууст хэр хүрч чадаж байгаа эсэхийг нь үнэлэх зорилготой юм. Үүний тулд дараах хэдэн зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд: (а) хөтөлбөрийн хамрах хүрээг тогтооход ашиглагдаж буй одоогийн томъёог хөтөлбөрийн үр нөлөө, хэмжээтэй холбож үзэх; (б) хөтөлбөрийн хэрэгжилтийг хялбарчлахын тулд энэхүү томъёог нь хэрхэн боловсронгуй болгох болох талаар яриа хэлэлцээр өрнүүлэх; (в) хөтөлбөрийн зорилготой уялдуулан үйл ажиллагааны зарим асуудлыг хэрхэн сайжруулж болох талаар судлах явдал юм.

Энэхүү тайлан нь 4 хэсгээс бүрдэнэ. Эхний хэсэгт салбарын бүтэц, зохион байгуулалт болон Дэлхийн банкнаас тус салбарт хийж буй ажлын талаар тоймлон танилцуулна. Хоёрдугаар хэсэгт ХМХ-тэй холбоотой орон нутгийн засаг захиргааны мэдээллийг авч үзэх, хөтөлбөрийн хамрах хүрээний газарзүйн хуваарилалтыг үнэлнэ. Гуравдугаар хэсэгт ХМХ-т хамрагдах өрхүүдийг тодорхойлоход ашиглагдаж буй томъёоны үзүүлэлтүүдийг үнэлэх загварыг танилцуулна. Сүүлийн хэсэгт ХМХ-ийн ядуучуудад үзүүлэх үр нөлөөг нь дээшлүүлэхийн тулд шинэчлэн сайжруулах зөвлөмжүүдийг оруулсан.

1. Удиртгал: Монгол улсын нийгмийн халамжийн салбар ба Хүүхдийн мөнгөний хөтөлбөр

Монгол улсын нийгмийн халамжийн тогтолцоо нь дараахь хоёр бүлэг хөтөлбөрүүдээс бүрддэг. Үүнд: (а) нийгмийн даатгал (өндөр насны тэтгэвэр, ажилгүйдэл, өвчний тэтгэлэг); (б) нийгмийн халамжийн тусламж (эмзэг бүлгийн тусгай тэтгэмжүүд, үүнд хөдөлмөрийн чадвараа алдасны болон олон хүүхэдтэйн тэтгэмж). Хүүхдийн мөнгөний хөтөлбөр хоёр дахь хэсэгт нь хамаарна.

Нийгмийн халамжийн харилцааг зохицуулдаг эрх зүйн гол баримт нь 1995 онд батлагдсан Нийгмийн халамжийн хууль, 2001 оны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль юм. Эдгээрээс гадна 2003 оны 1-р сард Монгол Улсын Засгийн газраас Нийгмийн халамжийн салбарын Мастер төлөвлөгөөг баталсан. Мастер төлөвлөгөөнд нийгмийн халамжийн тусламжийг дараах чиглэлээр өөрчлөн шинэчлэхээр тусгасан: (а) тусламжийн тоо, төрлийг цөөлөх; (б) тус салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх үүднээс төрөл бүрийн тэтгэлэгт хамрагдах шалгууруудыг нарийвчлан тогтоох; (в) нийгмийн халамжийн үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт дахь төвлөрлийг сааруулах; (г) нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэдэг боловсон хүчний мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх; (д) халамж үйлчилгээний зарим байгууллага дахь орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг юм.

Эдгээр шинэчлэлийн хэрэгжилтийн явц удаашралтай байна. 2006 онд Дэлхийн банкнаас гаргасан Монгол Улс дахь ядуурлын үнэлгээний тайлангийн нэг бүлгийг нийгмийн халамж, тусламжийн асуудалд зориулсан. Энэхүү тайлан нь өрхийн амьжиргааны талаарх хамгийн сүүлийн үеийн тоо баримтад тулгуурлан нийгмийн халамжийн гол хөтөлбөрүүдийн хамрах хүрээнд дүн шинжилгээ хийж, ядуурлыг бууруулахад тэдгээрийн оруулж буй хувь нэмрийг загварчлан гаргасан. Ядуурлын үнэлгээнээс гурван чухал дүгнэлт гаргасан. Нэгдүгээрт, тусламжийн томоохон хэсэг нь ядуу биш хүмүүст очдог. Бодит байдал дээр ядуу биш бүх өрхийн 70% нь ямарваа нэгэн нийгмийн хамламжийн тусламжид хамрагддаг байна. Хоёрдугаарт, ядуу өрхийн нэлээд хэсэг нь эдгээр тусламжид хамрагдаж чадалгүй гадна нь үлддэг. Тухайлбал, тус орны нийт ядуучуудын 40 хувь нь нийгмийн халамжийн ямар ч тусламж хүртэдэггүй. Гуравдугаарт, тусламжид хамрагдах хүмүүсийг тодорхойлох ажил тааруу хийгддэгийн шууд нөлөөгөөр нийгмийн халамжийн тусламж байхгүй бол ядуурлын тархац 36 хувиас 40 хувь хүртэл 10 хувиар өсөхөөр байна.

Шинээр бүрэлдэн тогтож буй нийгмийн халамжийн тогтолцоотой уялдуулан ЗГ-аас 2005 оны 1 дүгээр сараас эхлэн ХМХ-ийг хэрэгжүүлж эхэлсэн.

Хүүхдийн мөнгөний хөтөлбөр

ХМХ нь 2006 оны 2 дугаар сар хүртэл засгийн эрхийг барьсан эвслийн засгийн газрын нийгмийн салбар дахь гол хөтөлбөр байсан. ХМХ нь нийгмийн халамж, тусламжийн хуучин системээс дэвшилттэй, ядууст чиглэсэн шинэлэг шинж чанаруудыг агуулсан хөтөлбөр болсон юм.

ХМХ-ийг болзолт мөнгөн тэтгэлэг хэлбэрээр анхлан боловсруулсан. 0-18 насны хүүхдүүдтэй ядуу өрхүүдийг хамруулахаар анхлан төлөвлөж байсан. Мөнгөн тэтгэлгийг хүртэхийн тул хүүхдээ зайлшгүй хийлгэх вакцинд хамруулсан байх, хүүхэд нь эцэг эхтэйгээ цуг амьдардаг байх, хүүхэд тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлдэггүй байх зэрэг нөхцлийг хангах шаардлагатай байсан. Үүнээс гадна 8-18 насны хүүхдүүдийн хувьд хүүхэд сургуульд явдаг байх ёстой гэсэн болзол нэмэгдэж ордог байсан.

ХМХ нь ядуучуудад тусгайлан чиглэсэн нийгмийн тусламжийн шинэ хэлбэрийн хөтөлбөрийн анхдагч нь болсон. Энэ нь Монголын нийгмийн халамжийн тогтолцооны уламжлалт үйлчилгээнээс дараах хоёр шинж чанараараа ялгаатай байсан: (а) тэтгэлгийг хүлээж авч буй өрхүүдэд тодорхой нөхцөл тавьсан; (б) ядуучуудыг тодорхойлохын тулд төлөөлүүлэх аргыг нэвтрүүлсэн. Энэ хоёр шинж чанар нь ХМХ-ийг ядуурлыг бууруулах бусад стратегиас онцлогтой болгож байгаа юм. Нөгөө талаас, ХМХ нь тэтгэлэгт хамрагдах хүмүүсийг бодиттой бөгөөд цогц шалгууруудын дагуу эрэлт хэрэгцээг нь үндэслэсэн сонгох зарчмыг нэвтрүүлсэн бөгөөд хуучин системийн үед орон нутгийн засаг захиргаа үзэмжээрээ урьдчилан сонгодог байсныг халах боломжийг бүрдүүлсэн. Мөн түүнчлэн ХМХ нь айл өрхүүдэд ойр зуурын эрэлт хэрэгцээгээ хангах мөнгөн тэтгэмж олгосноор хүүхдийнхээ боловсрол, хөгжилд хөрөнгө оруулах явдлыг хөхүүлэн дэмжиж, улмаар ядуурлыг бууруулах боломжийг олгож байна.

Мөнгөн тэтгэлэгийн хэмжээ нь хүүхэд бүрт сар бүр 3,000 төгрөг (ойролцоогоор 2.60 ам. доллар) болж байна. 2005 оны 12 дугаар сар хүртэл хөтөлбөрт хамрагдсан айл өрхүүд сардаа дунджаар 5.20 ам. доллар авч байсан нь 2002 оны амьжиргааны түвшний судалгаагаар тогтоосон амьжиргааны баталгаажих доод түвшний 25 хувьтай тэнцэж байгаа юм.

ХМХ-т хамруулах үйл явц, мөн хөтөлбөрийн бодит хэрэгжилтийг хянаж үзэх нь тус хөтөлбөрт байгаа дутагдалтай талуудыг ойлгоход чухал ач холбогдолтой юм.

ХМХ-ийн хэрэгжилт, хамрах хүрээг тогтоох ажлын удирдлага төвлөрсөн бус хэлбэрээр хийгдэж байгаа бөгөөд дараах үе шатуудыг дамжиж байна:

- а. Баг, хорооны¹ засаг дарга нар өөрсдийн хариуцсан нутаг дэвсгэрт оршин сууж буй ядуу өрх тус бүрээр “Өрхийн амьжиргааны талаарх ерөнхий мэдээллийн санал асуулгын хуудсыг” бөглөдөг. Энэхүү хуудсыг бөглөсний дараа засаг дарга тухайн өрхийн орлогын байдалд тулгуурлан ядуурлын түвшнийг нь тогтоох ёстой. Энэхүү шүүлтүүр нь Монголд хэрэгждэг нийгмийн халамжийн уламжлалт хөтөлбөрүүдийн хувьд хэвшил болсон зүйл юм. Энэхүү үйл явцад хувь хүний үзэмжээр шийдэх явдал түгээмэл байдгийг нэлээд дурддаг. Энэхүү үйл явц нь ХМХ-т хамруулах хоёр үе шаттай үйл явцын эхний шат байгаа юм. Баг, хороод нь Монгол улсын засаг захиргааны хамгийн бага нэгж юм.
- б. Засаг дарга нарын үзэж буйгаар ядууд тооцогдсон өрхүүд нь ХМХ-ийг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт хариуцаж буй нийгмийн халамжийн ажилтнуудтай² уулзана. Тухайн ажилтнууд судалгаа хийнэ. Энэхүү судалгаанд орж буй бүх мэдээлэл хүмүүсийн төлөөлүүлэх аргын оноог тодорхойлоход ашиглагдана. Оноо өгөх ажлыг хөтөлбөрийн ажилтнууд ихэвчлэн гараар хийнэ. Компьютер байгаа тохиолдолд Эксел программыг ашиглан хийнэ.
- в. ХМХ-т бүртгүүлэхийн тулд эцэг эхчүүд дараахь бичиг баримтыг хөтөлбөрийн ажилтанд бүрдүүлж өгөх хэрэгтэй: (i) эцэг, эхийн иргэний баримт бичиг; (ii) хүүхдүүдийн төрсний гэрчилгээ; (iii) эцэг эхийн гэрлэлтийн баталгаа, (iv) вакцинд хамрагдсан эсэх тодорхойлолт; (v) 8-18 настай бүх хүүхдүүд сургуульд сурдгийг гэрчлэх тодорхойлолт; (vi) “Өрхийн амьжиргааны талаарх ерөнхий мэдээллийн санал асуулгын хуудас” зэрэг юм.
- г. Өрхийг ХМХ-т бүртгэж авсны дараа хөтөлбөрийн ажилтнууд бүртгүүлсэн хүүхдийн нэр дээр дэвтэр нээж өгдөг. Сар тутам хүүхэд тус дэвтэрийг авч хөтөлбөрийн ажилтанд үзүүлэн гарын үсгийг нь зуруулаад ХААН банкинд³ очиж мөнгөө авдаг. Өрхүүд энэ мөнгийг заавал сар бүр авах албагүй бөгөөд хуримтлуулж байгаад авсан ч болдог. Гэхдээ хүү бодогддоггүй.
- д. Банкууд ХМХ-т хамрагдагсдад хичнээн хэмжээний мөнгө төлснөө хөтөлбөрийн ажилтнуудад сар тутам тайлагнадаг. Гэхдээ хөтөлбөрийн нөхцөл болзлын хэрэгжилтийг тогтмол хянах систем байхгүй.

Хэдхэн сарын дотор хүүхдийн мөнгөний хөтөлбөр улсын төсөвт зарцуулдаг мөнгөний хэмжээгээрээ хамгийн том нийгмийн халамжийн хөтөлбөр болсон. Хөтөлбөрийн хамрах хүрээ ийнхүү хурдан өссөн нь тус хөтөлбөрийг санхүүгийн тогтвортой байдалд санаа зовоход хүргээд зогсохгүй, хамрах хүрээг нь тогтоох тал дээр асуудал байж магадгүйг илтгэсэн. Жил хүрэхгүй хугацаанд, Монгол улсад байгаа нийт ядуу өрхүүдээс хоёр дахин илүү тооны өрхүүд ХМХ-т хамрагдсан байсан. Иймээс энэхүү судалгаа нь хөтөлбөрт хамрагдагсдыг тодорхойлох асуудалд чиглэж байгаа юм. ХМХ-ийн улсын төсөвт үзүүлэх нөлөөтэй холбоотойгоор дурдах нэг зүйл бол 2005 оны 1-р сард эхэлсэн хөтөлбөр тухайн оны 12-р сар гэхэд 303,000 өрхийн 609,000 хүүхдэд хүрээд байсан. Хөтөлбөрт хамрагдагсдын тоо цаашид нэмэгдэхгүй байлаа ч

¹ Баг, хороод нь Монгол дахь засаг захиргааны хамгийн бага нэгж юм.

² Энэхүү тайланд хөтөлбөрийн ажилтнууд гэж засаг даргын тамгын газрын ажилтнуудыг хэлж байгаа бөгөөд тэдгээр нь дүүргийн түвшинд хөтөлбөрт хамрагдагсдыг бүртгэх, мөнгөө авсныг нь гэрчлэх үүрэгтэй. Монгол Улс 22 аймагт хуваагддаг бөгөөд аймгууд нь сумдад хуваагддаг. Тус улсад 340 сум, дүүрэг байдаг бөгөөд тэдгээрийн бүрэлдэхүүнд нийтдээ 1,671 баг, хороод багтдаг.

³ Хөдөө аж ахуйн банк нь мөнгөн шилжүүлгийн дүнгийн 2.3 хувьтай тэнцэх шилжүүлгийн төлбөрийг Засгийн газраас авдаг. (Хөдөөгийн сумдад 3.3%).

хөтөлбөрт зарцуулж буй мөнгөний хэмжээ 2006 оны ДНБ-ий 1.4 хувьтай тэнцэх төлөвтэй байна. 2004 оны ДНБ-ээс нийгмийн даатгал (6.4%) болон бусад бүх нийгмийн халамжийн тэтгэмжид (1.3%) зарцуулсан мөнгөтэй харьцуулахад энэ нь маш өндөр үзүүлэлт юм.

Төсвийн зарцуулалтын байр сууринаас харахад ХМХ-ийн хэмжээтэй холбоотой хэд хэдэн бэрхшээлтэй асуудлууд байгаа юм. Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас 2005 онд Монгол Улсын өрийн тогтвортой байдалд хийсэн судалгаанаас үзэхэд Монголын байр суурь эрсдэлтэй болох нь тогтоогдсон. Тус орныг санхүүгийн хувьд эрсдэлтэй болгож буй томоохон шалтгаануудын нэг нь төсвийн зарцуулалт хэт уян хатан биш байгаа явдал юм. 2000– 2004 оны хооронд (Хүүхдийн мөнгөний хөтөлбөр гарахаас өмнө) хороодыг нийгмийн халамжийн хөтөлбөрүүдэд хамруулахад төрөөс зарцуулсан мөнгөний хувь 3.7 хувиас 4.3 хувь болтол өссөн байна. ОУВС, Дэлхийн банкны хамтарсан тайлан төсвийн орлого зохих хэмжээгээр нэмэгдээгүй байхад хамрах хүрээ нь тодорхой биш нийгмийн халамжийн тусламжийн хэмжээг хурдацтай нэмэхгүй байхын ач холбогдлыг онцлон дурдсан. Иймэрхүү нийгмийн зарцуулалтыг хүмүүс өөрсдийн “авах ёстой тусламж” мэтээр үздэг нь амархан байдаг тул ирээдүйд эргээд багасгахад хэцүү болдог. Хүүхдийн мөнгөний хөтөлбөр гарч ирээд, маш хурдан хугацаанд хамрах хүрээ нь нэмэгдсэн нь ийм үйл явцын нэг жишээ юм.

Монголын нийгмийн халамжийн салбар дахь Дэлхийн банкны туслалцаа

Сүүлийн хоёр жилийн хугацаанд Дэлхийн банк монгол улсын нийгмийн хамгааллын салбарт Засгийн газартай бодлогын яриа хэлцэл хийх замаар оролцож байна. Дэлхийн банк тус салбарт үйл ажиллагаа явуулдаггүй боловч бодлогын яриа хэлэлцээрийг мэдээллээр хангах зорилгоор судалгаа шинжилгээний ажил хийсэн. Сүүлийн үеийн судалгааны ажлуудаас дурдахад нийгмийн халамжийн хөтөлбөр, хөдөөгийн эмзэг байдлын талаарх бодлогын тайлан бөгөөд түүнийг Ядуурлын үнэлгээний бэлтгэл ажлын хүрээнд 2005 оны 6 сард түгээсэн юм. Боловсрол, эрчим хүч, хөдөөгийн хөгжил зэрэг бусад салбар дахь үйл ажиллагаагаараа дамжуулан Дэлхийн банк нийгмийн халамжид шууд нөлөөлөх хөтөлбөрүүдэд туслалцаа үзүүлсэн. Жишээлбэл, Тогтвортой амьжиргааны төслийн (ТАТ) хүрээнд эмзэг бүлгийн малчдад багц санаачилгуудаа санал болгосон бөгөөд үүнд бэлчээрийн менежментэнд малчдын оролцоог нэмэгдүүлэх, малчдын бүлгүүдэд дэмжлэг үзүүлэх, хадлан, тэжээл бэлтгэх бизнесийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг багтаж байсан. ТАТ-өөс гадна Малын индексжүүлсэн даатгалын хөтөлбөрийн хүрээнд сайн дурын даатгал, зах зээлд тулгуурласан даатгал, нийгмийн даатгал зэрэгт хамруулахад дэмжлэг үзүүлснээр малын хорогдлоос үүдэлтэй ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулсан.

Эцэст нь 2005 оны хавраас Дэлхийн банк Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамтай ХМХ-ийн талаар бодлогын зөвлөлдөөнийг эрчимтэй хийж эхэлсэн бөгөөд тодруулбал хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр техникийн туслалцаа үзүүлэх болсон. Үүний хүрээнд дараахь үйл ажиллагаа явагдаж байна. Үүнд:

- a. 2005 оны 7-р сард Дэлхийн банк ХМХ-ийн хамрах хүрээг тодорхойлоход ашиглагдсан төлөөлүүлэх аргад дүн шинжилгээ хийж Засгийн газарт танилцуулсан.
- b. 2005 оны 11-р сард хөтөлбөрийн хамрах хүрээг тодорхойлоход одоо ашиглагдаж буй төлөөлүүлэх аргын томъёоны талаар мэдээллэх, түүнийг бусад хувилбаруудтай харьцуулан тайлбарлах илтгэлийг тавьсан. Энэхүү тайланд судалгааны талаар яригдана.

- в. Дэлхийн банк НХХЯ-тай хамтран ХМХ-т хамрагдагсдын мэдээллийн санг байгуулах туршилтын төслийг санхүүжүүлсэн бөгөөд энэхүү мэдээллийн санг Засгийн газар тус хөтөлбөрийн хяналт, үнэлгээг хийхдээ ашиглаж болохоос гадна Засгийн газрын бусад хөтөлбөрт хамрагдах хүмүүсийг тодорхойлохдоо ашиглаж болох юм.
- г. Дэлхийн банк нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Үндэсний статистикийн газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран ХМХ-т хамрагдагсдыг хэр үнэн зөв тодорхойлсныг үнэлэх, айл өрхүүдийн зарцуулалт, хүүхдээ сургуульд хамруулах сонголтод ХМХ хэр нөлөөлж байгааг үнэлэх зорилгоор айл өрхийн түвшний тоо баримт, мэдээллийг цуглуулах ажлыг хийж байна. Энэхүү ажил нь ХМХ-ийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны үнэлгээний хамтаар 2007 оны санхүүгийн жилд хийх ажлын төлөвлөгөөнд багтсан ААА төрлийн судалгааны ажил юм.

Энэ салбар дахь бусад хандивлагчдын оролцоо

Нийгмийн салбарт ихээхэн хэмжээний хөрөнгө оруулж буй хандивлагч бол Азийн хөгжлийн банк (АХБ) бөгөөд Нийгмийн халамжийн салбарыг хөгжүүлэх хөтөлбөрөөрөө дамжуулан туслалцаа үзүүлж байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд нийтдээ 12 сая ам. долларын бодлогын болон хөрөнгө оруулалтын зээлийг олгож байгаа бөгөөд 720,000 ам. долларын техникийн туслалцаа үзүүлж байна. АХБ-ны нийгмийн хамгааллын салбар дахь тусламж нь энэ салбарт олон нийтийн оролцоог дээшлүүлэх, тусламжийн хамрах хүрээг зөв тогтоох чадварыг бэхжүүлэхэд голчлон чиглэж байна. Хөрөнгө оруулалтын төслийн хүрээнд нийгмийн халамжийн байгууллагуудын орчин нөхцөл, тоног төхөөрөмжийг сайжруулж шинэчлэх ажлыг санхүүжүүлэх юм. Түүнчлэн хөдөлмөрийн зах зээлийн бодлогод дэмжлэг үзүүлэх (сургалт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын нөхцлийг сайжруулах г.м.) бөгөөд үүний дотор мэдээллийн технологи, мэдээллийн сангийн менежментийн чиглэлээр дэмжлэг үзүүлэх юм.

2. Аймгийн түвшинд ХМХ-т хамрагдсан байдал, амьжиргааны зөрөө


ХМХ-ийн улс даяар хэрхэн хүрээгээ тэлж байгааг хянах боломжийг олгож буй засаг захиргааны нэгжээс ирсэн тоо баримт нь аймгуудын хөтөлбөрт хамрагдсан өрх, хүүхдүүдийн тоо юм. Хөтөлбөрийн газар зүйн тархалт нь хүмүүсийн амьжиргааны түвшинтэй ямар уялдаатай байгааг жишин үзэхэд тус дөхөм болохуйц ядуурлын газрын зураглал эсвэл хөдөө орон нутгийн нийгэм-эдийн засгийн мэдээлэл Монгол улсад одоогоор байхгүй ч хөтөлбөрийн хамрах хүрээг 2000 оны тооллогын дүнтэй харьцуулж болох юм. Эдгээр харьцуулалтын талаар энэ хэсэгт яригдана.

1-4-р зурагт аймгийн түвшин дэх ХМХ-ийн тархалтыг тухайн аймгийн хэд хэдэн төрлийн мэдээлэлтэй харьцуулан дүрсэлсэн. Баримт мэдээллийн олдоч хязгаарлагдмал байгаа учраас хөтөлбөрийн хамрах хүрээг тодорхойлохдоо хөтөлбөрт хамрагдсан нийт хүүхдийн тоо болон аймгийн хүн амын тооны хоорондын харьцаагаар тооцоологдсон нарийвчлалтай бус үзүүлэлтийг ашигласан. Энэ үзүүлэлт нь хөтөлбөрт бодитоор хамрагдсан хүмүүсийн тоог дутуу үнэлсэн үзүүлэлт юм. Гэхдээ энэ үзүүлэлтийг ашиглан харахад хөтөлбөрийн хамралтын байдал аймгуудын хувьд ялгаатай нь харагдаж байгаа бөгөөд 15%-аас 55%-ийн хооронд буюу дунджаар 25 хувьтай байна. Хавсралт 1-д 1-4 дүгээр зурагт дүрсэлсэн мэдээллийг багтаасан.

Сонирхолтой нь аймгууд өөр бусад үзүүлэлтүүдээрээ хоорондоо ялгаатай бөгөөд энэ ялгаа нь аймгуудын хүн амын амьжиргааны дундаж түвшинд нөлөөлдөг. 1-р зурагт

ХМХ-ийн хамрах хүрээ болон нийт хүн амд боловсролгүй хүмүүсийн эзлэх хувийг харьцуулан үзүүлсэн. Хүн амын тооллогод бага боловсролгүй хүмүүсийг боловсролгүй хүнд тооцсон. Гэхдээ 10 болон түүнээс дээш насаар зааглан тооцдог тул 1-4 дүгээр ангид сурч буй хүүхдүүдийг хамруулдаг учир хэтрүүлсэн үзүүлэлт юм. Боловсролгүй хүмүүсийн эзлэх хувь өндөртэй аймгууд бусад аймгуудтай харьцуулбал амьжиргаа доогуур байх ёстой тул улмаар ХМХ-т хамрагдсан хүний тоо өндөр байх ёстой гэж тооцоолж байсан. Үнэхээр ч зургаас харахад ХМХ-ийн хамрах хүрээ болон боловсролгүй хүмүүсийн тооны хооронд эерэг хамаарал байгааг тогтоосон ч энэхүү хоёр үзүүлэлтийн хоорондын хамаарал сул байгаа бөгөөд гадны хүчин зүйлээс хамаарч байгаа юм. Үнэхээр ч тухайн хоёр үзүүлэлтийн хоорондын хамаарал 0.25 байгаа бөгөөд Улаанбаатарыг хасчихвал 0.09 хүртэл буурч байгаа юм.


Зураг 1 ХМХ-ийн хамрах хүрээ ба хүн амын боловсролгүй хэсэг



Хүн амын боловсролгүй хэсэг/Хүн ам

ХМХ-ийн хамрах хүрээг хүний амьжиргаанд нөлөөлөхүйц нийгэм-эдийн засгийн бусад үзүүлэлтүүдтэй харьцуулан үзэхэд, тухайлбал хөдөө орон нутагт амьдарч буй хүний эзлэх хувь (Зураг 2) эсвэл цэвэр шилжилт хөдөлгөөн зэрэг үзүүлэлттэй харьцуулж үзэхэд Зураг 1-т байсантай төстэй хандлага ажиглагдсан. Зураг 2-т агуулагдаж буй санаа бол ядуурлын газарзүйн тархалттай уялдан хөдөөгийн хүн амын эзлэх хувь өндөртэй аймгууд илүү ядуу байх хандлагатай байна. Нөгөө талаас эдийн засгийн боломж харьцангуй өндөртэй, амьжиргааны түвшин дээгүүр аймгууд шилжин суурьшигчдыг татах магадлал өндөртэй байдаг.


Зураг 2 ХМХ-ийн хамрах хүрээ ба хөдөөгийн хүн ам



Хөдөө амьдардаг хүний эзлэх хувь


Зураг 2 ба 3-аас үзэхэд ХМХ-ийн хамрах хүрээ болон аймгуудын үзүүлэлтүүдийн хооронд мөн л сул харилцан хамаарал ажиглагдаж байна. ХМХ-ийн хамрах хүрээ болон хөдөө амьдардаг хүн амын хоорондын харьцаа дөнгөж 0.10 байна. Түүгээр ч зогсохгүй Улаанбаатарыг эс тооцвол тус хамаарал сөрөг гарч байгаа нь (-0.08) хөдөөгийн хүн амын эзлэх хувь өндөртэй аймгууд ХМХ-т хамрагдах хувь нь бага гарч байна гэсэн үг. Эцэст нь цэвэр шилжилт хөдөлгөөн болон ХМХ-ийн хамрах хүрээний хоорондын харьцаа сөрөг үзүүлэлттэй байгаа хэдий ч энэ хамаарал нь мөн л сул бөгөөд Улаанбаатар орсон нь үүнд нөлөөлж байна. (Улаанбаатарыг хасвал -0.16 ба -0.08 болно).

Зураг 3 ХМХ-ийн хамрах хүрээ болон цэвэр шилжилт хөдөлгөөн



Зураг 1-3 дахь ХМХ-ийн хамрах хүрээг илэрхийлэхдээ 2005 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн тоо баримтыг ашигласан боловч засаг захиргааны мэдээллүүд сар тутам солигддог. 6 сараас 11 сарын хооронд хөтөлбөрийн хамрах хүрээ хэрхэн өргөжсөнийг харьцуулах нь их сонирхолтой. Учир нь 7 сарын 1-ний өдрөөс эхлэн хөтөлбөрт хүүхэдтэй ядуу өрх бүр хамрагдах болсон. (Түүнээс өмнө зөвхөн 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхүүд хамрагдаж байсан) 6 сараас 11 сарын хугацаанд хөтөлбөрийн хамрагдах хүний тоо хамгийн ихээр нэмэгдэх газар нь гэр бүлийн дундаж хэмжээ багатай газрууд байх ёстой баймаар. Гэтэл зургаас үзэхэд тухайн хоёр үзүүлэлтийн хооронд аливаа хамаарал харагдахгүй байгаа тул хөтөлбөрийн өсөлт нь түүнд шинээр хамрагдах эрх олж авсан хүмүүсээс голчлон хамаарахгүй байгаа нь харагдаж байна.

Зураг 4 12-р сараас 6-р сар хүртэлх хугацааны хөтөлбөрийн өсөлт болон гэр бүлийн дундаж хэмжээ



Засаг захиргаанаас авсан болон тооллогын тоо баримт алдаатай байж болох хэдий ч эдгээр 4 зургаас үзэхэд ХМХ-ийн хамрах хүрээг тодорхойлох ажилд дутагдал байгаа нь харагдаж байна. Хөтөлбөрийн орон нутаг дахь хамрах хүрээ нь амьжиргааны түвшинтэй нягт уялдаа бүхий нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүдтэй сул хамааралтай байна. Нийгмийн халамжийн салбарт шинээр нэвтэрч буй үйл ажиллагааны нэг хэмээн тооцогддог ХМХ-ийн онцлог шинжүүдийн нэг нь тус хөтөлбөр иргэдийн амьжиргааны түвшинг бодиттойгоор үнэлсэнээр хамрах хүмүүсээ тогтоодогт оршиж байгаа юм. Үүнээс үзэхэд ХМХ-ийн үр нөлөөг бууруулж буй саад бэрхшээлийг илрүүлэхийн тулд хөтөлбөрийн төлөвлөлт, түүний хамрах хүрээг тодорхойлох томъёог сайтар судлах шаардлагатайг харуулж байна.

3. Загварчлах арга барилд тулгуурласан хөтөлбөрийн хамрах хүрээг тодорхойлох томъёоны үнэлгээ

Энэ хэсэгт ХМХ-т хамрагдагсдыг тодорхойлоход ашиглагдсан төлөөлүүлэх аргын томъёонд дүн шинжилгээ хийхэд ашигласан аргачлалын талаар ярих болно. Тус томъёог Ядуурлын эрсдлийн коэффициент хэмээн нэрлэж байгаа бөгөөд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Сангийн яамны ядуурлын судалгааны нэгжийн хамтын ажиллагааны үр дүнд бий болсон юм.⁴

ЯЭК-ийг ядуурал болон түүнтэй холбоотой олон үзүүлэлтүүдийн хоорондын харьцаанаас гаргаж авсан. ЯЭК нь өрхийн түвшний олон тооны үзүүлэлтүүдийн (өмч хөрөнгийн эзэмшил, орон байрны нөхцөл, орлого ологчид, тусламж хүртэх боломж зэрэг) нийлбэрээр илэрхийлэгдэнэ. Хавсралт 2-т ЯЭК-ийн хувьсагчдыг

⁴ Тус аргын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Сангийн яамны ядуурлын судалгааны нэгж, НҮБХХ-өөс 2005 онд хамтран гаргасан “Өрх, иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг ижил хөгжилтэй бусад орныхтой харьцуулсан судалгаа”-наас харж болно.

илэрхийлсэн. Эдгээр хувьсагчдын жин нь амьжиргааны эдгээр үзүүлэлтүүдийн аль нь ядуучуудын хувьд “хэтэрхий ахадсан” болохыг тодорхойлоход дөхөм болно. Хувьсагчдын жинг гаргахдаа i хэлбэрийн ядуу хүмүүсийн эзлэх хувийг тухайн хэлбэрийн хүмүүсийн нийт хүн амд эзлэх хувьд харьцуулах замаар гаргаж авна.

$$\left(\frac{i \text{ хэлбэрийн ядуусын эзлэх хувь}}{i \text{ хүмүүсийн хүн амд эзлэх хувь}} \right).$$

Хувьсагчдын жинг орон даяар тооцоолдог ч мал өмчлөх гэх мэт хувьсагчдыг хөдөөгийн ЯЭК-д нэмж оруулдаг. Тухайн аль нэг гэр бүлийн үзүүлэлтүүдийн нийлбэрийг томъёон дахь хувьсагчдад хуваахад 1-ээс илүү хариу гарч байвал ХМХ-т хамрагдах боломжтой гэр бүл гэсэн үг. Өөрөөр хэлбэл, ихэнх үзүүлэлтийн хувьд тухайн гэр бүл нь улсын дундаж ядуу өрхтэй адил байна гэсэн үг.

Хөтөлбөрийн хамрах хүрээг тодорхойлох төлөөлүүлэх аргын системд шилжсэнээр Монголын нийгмийн халамжийн тогтолцоонд асар том дэвшил гарсан. Гэхдээ арга зүйн хувьд ЯЭК-ийн хамгийн том дутагдалтай тал нь ядуурал болон өрхийн шинж чанаруудын хоорон дахь олон талт бус хоёр талын харилцаанд тулгуурлан гаргаж ирсэн үзүүлэлт юм.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас тавьсан хүсэлтийн дагуу Дэлхийн банк өөр аргачлалын үр дүнгийн талаар танилцуулах гэж байна. Энэ аргууд нь үзүүлэлтүүд болон тэдний жинг нэг мөр тодорхойлдог бөгөөд үзүүлэлт тус бүрийн жинг бусад үзүүлэлтүүдийг тооцсон байдлаар тодорхойлдог. Энэхүү дүн шинжилгээний талаар дараагийн хэсэгт яригдана. Гэхдээ энд онцлон тэмдэглэх хэрэгтэй нэг зүйл бол хөтөлбөрийн хамрах хүрээг тодорхойлох өөр томъёог ашиглаж эхлэхээсээ өмнө улс орны өнцөг буланд байгаа нийгмийн ажилтнуудыг оролцуулан тухайн томъёоны найдвартай эсэхийг баталгаажуулах хэрэгтэй. Бидэнд одоогоор илэрхий болоод байгаа зүйл бол ХМХ-ийг ямар ч туршилтгүйгээр орон даяар хэрэгжүүлж эхэлсэн нь нэлээд их хэмжээний зардал гаргасан. Энэхүү сургамжаас үзэхэд туршилт хийх, хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжилтэд аажим шинэчлэл хийх нь чухал болох нь харагдаж байна.

Энэ хэсэгт танилцуулж буй арга хэмжээ нь 2002 оны амьжиргааны түвшний судалгаанд тулгуурлан гаргасан загварт үндэслэгдсэн юм. ХМХ 2005 оны 1-р сараас хэрэгжиж эхэлснээс хойш Амьжиргааны түвшний судалгаатай төстэй судалгаа хийгдээгүй тул 2002 оны судалгаа нь ядуурал, өрхийн амьжиргааны үзүүлэлтүүдийг орон даяар тодорхойлсон хамгийн сайн эх сурвалж болсон. Гэхдээ энэхүү тайланд ХМХ-ийн хамрах хүрээг тодруулах чиглэлээр 2005 онд хийсэн ажлыг 2002 оны тоо баримтад тулгуурлан үнэлэхийг оролдож байгаа тул 2002–2005 оны хооронд Монголд зарим нэг өөрчлөлтүүд гарсныг дурдах нь зүйтэй юм. Ялангуяа 2002 оноос хойших хугацаанд ДНБ-ний хэмжээ мэдэгдэхүйц өссөнийг дурдах хэрэгтэй. 2003 онд ДНБ-ний бодит өсөлт 5.6% байсан бол 2004 онд 10.6%-д хүрсэн. Эдийн засгийн зарим өсөлт нь цаг агаарын бэрхшээлээс болж ихээхэн хэмжээний алдагдалд орсон мал аж ахуйн салбар эргэн хөл дээрээ босч байгаатай холбоотой боловч эдийн засгийн өсөлтийн нэлээд хувь нь ашигт малтмалын үнийн өсөлт, уул уурхайн салбарын өргөжилттэй холбоотой. Тухайн хугацаанд ажилгүйдлийн түвшин нэг их өөрчлөгдөөгүй, бага зэрэг л нэмэгдсэн. Эдийн засгийн өсөлтийн шинж чанараас үзэхэд тухайн өсөлтөөс ядуучууд үр ашиг хүртсэн гэж бодогдохгүй байна. Гэхдээ үр ашгаа өгсөн байлаа ч 2002 оны тоо баримтад тулгуурласан судалгааны үр дүн нь алдаатай байж болзошгүй. Учир нь ядуурлыг хэмжээг хэтрүүлэн тогтоож, ХМХ зэрэг нийгмийн халамжийн хөтөлбөрт хамрагдах эрхтэй хүмүүсийн тоог илүүгээр тогтоосон байж болох татлай. Сүүлийн үед эдийн засагт гарсан өсөлттэй холбоотойгоор шинээр бий болж буй баялгаас ядуучуудад хүртээхээр хуваарилах

нь улам ч чухал болж байна. Нийгмийн халамжийн тогтолцоог хэрэгтэй хүнд нь зөв чиглүүлж өгөх нь хувь нэмэрээ оруулах нь дамжиггүй. Энэ нь уг тайлан дахь дүн шинжилгээг хийх бас нэгэн шалтгаан болж байна.

Энд дурдвал зохих нэг чухал зүйл бол тус дүн шинжилгээг хөтөлбөрт хамрагдаж буй хүмүүсийн талаарх бодит тоо баримтыг түшиглэн биш харин дан ганц үлгэрчилсэн загварт тулгуурлан хийсэн юм. Байгаа мэдээлэлд тулгуурлан судалгаан дахь зургууд ХМХ-ийн төлөвлөгөө ёсоор түүний хамрах хүрээг хэрхэн тогтоох ёстой байсныг үзүүлсэн. Гэхдээ хөтөлбөрт хамрагдах үйл явц энд яригдаж байгаагаас өөрөөр явагдсанд нөлөөлсөн ямар бэрхшээл, асуудал хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад гарсан эсэхийг эмпирик судалгаа тодруулж чадахгүй.

Судалгааг дараах логикт үндэслэн хийлээ. Нэгдүгээрт, өрхийн амьжиргааны судалгаанд үндэслэн ЯЭК-ийг гаргаж авсан. Дараа нь хөтөлбөрт хамрагдагсдыг тогтоох хувилбаруудыг гаргаж, ЯЭК-ын үзүүлэлтүүдтэй харьцуулна. Хөтөлбөрт хамрагдагсдыг тогтоох олон аргуудыг үнэлэх “Алтан дүрэм” нь Өрхийн амьжиргааны түвшний судалгаанаас тогтоосон өрхийн хэрэглээ (ядуурал) юм.

Өрхийн амьжиргааны түвшний судалгааг ашиглан ЯЭК-ийг төгс тооцоолон гаргаж болохгүй. Учир нь ЯЭК-ийн зарим нэг хувьсагчид нь нэг бол судалгаанд байхгүй эсвэл арай өөрчлөгдсөн байдлаар орсон байж болно. Хавсралт 2-т үлгэрчилсэн загварт ороогүй хувьсагчдыг хүснэгтийн сүүлийн багананд “Х” тэмдгээр тэмдэглэсэн. Мөн тухайн багананд шаардлагатай тохиолдолд хувьсагчийн тодорхойлолтод орсон өөрчлөлтийг тайлбарласан. Хувьсагчдын жагсаалтад өөрчлөлт оруулах шаардлагатай байсны улмаас тухайн хувьсагчдын ЯЭК дахь жинг ӨАТС-г ашиглан дахин тогтоох хэрэгтэй болсон. Хөтөлбөрт хамрагдагсдыг тодорхойлоход ашиглагдах ЯЭК-ийг тодорхойлсны дараа ихэнх хувьсагчдын жинг улс даяар тооцоолон гаргасан. ЯЭК-д хот, хөдөөгийн ялгаа оруулсан тохиолдолд тэдгээр хувьсагчдын жинг тооцоолох, загвар гаргахдаа тухайн ялгааг тооцож үзсэн.

Хүснэгт 1-д ӨАТС-г ашиглан гаргаж ирсэн хөтөлбөрт хамрагдагсдыг тодорхойлох аргуудын хувилбаруудыг танилцуулах бөгөөд тэдгээрийн шинж чанарыг ЯЭК-ийн шинж чанартай харьцуулж үзсэн. C and C1 загварууд нь нэг хүнд ноогдох хэрэглээний логаритм дээрх хамгийн бага квадратын арга юм. Тайлбарлах хувьсагчид учраас тэдний аль аль нь хэрэглээг хамгийн сайнаар тайлбарлаж чадах өрхийн түвшний хувьсагчидтай байдаг⁵.

Хоёр загварын хооронд хоёр томоохон ялгаа бий. Нэгдүгээрт, C загвар нь ЯЭК-д ордог ижил хувьсагчдын дундаас хамгийн тохиромжтой хувьсагчдыг зурдаг. Харин C1 загвар өрхийн амьжиргааны түвшнийг сайн илэрхийлж чаддаг зарим нэг нэмэлт хувьсагчдыг өөртөө багтаадаг⁶. Хоёрдугаарт, C загвар хоёр тусдаа загварыг үлгэрчлэн үзүүлдэг бол (Улаанбаатар, аймгийн төв гэх мэт суурин газарт зориулсан нэг, сумын төв, хөдөөд зориулсан бас нэг) C1 загвар судалгааны бүлэг тус бүрт нэг нийт 4 тусдаа загварыг тооцоолдог (ЕУБ, аймгийн төв, сумын төв, хөдөө). Өөр өөр газарзүйн бүсэд зориулсан тус тусдаа тэгшитгэлүүдийг бодох нь хүмүүсийн амьжиргааны түвшин болон өрхийн шинж чанарын хоорондын холбоог загварчлан үзүүлэх ажлыг илүү уян хатан болгож өгдөг.

Эцэст нь хэлэхэд, PC загвар нь үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг ашиглан ядуурлын индексийг тогтоодог⁷. Хэрэглээний талаарх мэдээлэл байгаа тохиолдолд ашиглаж

⁵ Энэ нь урвуу шатлалаар үнэлгээ хийх үйл явц бегеед загвараас хасахын үр дагаврын түвшнийг 0.2, загварт нэмж оруулахын үр дагаврын түвшнийг 0.1 хэмээн урьдчилан тодорхойлсон байна.

⁶ C1 загварт нэмж орсон хувьсагчид нь: (i) өрхийн тэргүүний талаарх мэдээлэл (нас, хүйс); (ii) өрхийн тэргүүний гэр бүлийн хүний талаарх мэдээлэл (байгаа эсэх, боловсролын түвшин); (iii) нийтийн үйлчилгээнд хамрагддаг эсэх (усан хангамжийн төрөл, хог хаягдал зайлуулах, бохир усны систем, телефон утас, цахилгаан эрчим хүч); (iv) байр орон ёууцны нөхцөл (бие засах газрын төрөл, гал тогоо, ванн, халаалтын түлш); (v) бусад

⁷ PC буюу Үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд нь өрхийн орлого, хэрэглээний талаар мэдээлэл байхгүй үед халамжийн арга

болох хоёр дахь сайн арга бөгөөд ядуурлыг бууруулахад чиглэсэн хөтөлбөрүүдэд элбэг ашиглагддаг арга юм. Энэ нь С1 загварт зориулан сонгосон хэрэглээнд хамгийн сайн тохирох хувьсагчдыг л ашигладаг⁸.

Хүснэгт 1 Хөтбөрт хамрагдсдыг тодорхойлох нэмэлт аргууд

| | С: | С1: урьдчилан таамагласан хэрэглээ | ҮБ: Үндсэн бүрэлдэхүүн |
|-----------------------------------|---|---|-------------------------------|
| Арга | Хэрэглээнд суурилан байгуулсан регрессийн шугам | | Үндсэн бүрэлдэхүүн |
| Уялдаа | ЯЭК-тэй адил | ЯЭК-тэй адил + бусад | |
| Хувьсагчийг сонгор шалгуур | Хамгийн тохиромжтой | Хамгийн тохиромжтой | С1-тэй ижил |
| Үнэлгээний түвшин | Хотын Хөдөөгийн | УБ, аймгийн төв, сумын төв, хөдөө | Үндэсний |

Судалгаанд хамрагдсан айл өрхүүдийн амьжиргааны түвшингийн эдгээр жишгүүдийг тодорхойлоход ӨАТС-г ашигласан. Дараагийн алхам нь эдгээр жишгүүд нь өрхийн хэрэглээтэй харьцуулахад өрхүүдийг амьжиргааг нь таамаглах, тэднийг зэрэглэхдээ хэр зэрэг тохиромжтой гэдгийг үнэлэх явдал юм.

Хамрагдагсдын тоо

Эхний асуулт бол ядуурлыг загварчлан үнэлэх эдгээр аргуудын аль нэгийг ашиглах тохиолдолд хөтөлбөрт хамрагдах болзлыг хэр олон өрх хангах вэ гэдэг асуулт юм. ӨАТС-наас үзэхэд Монгол Улсад 0-18 насны хүүхэдтэй 434,000 өрх бий. Тэдгээрээс 146,000 өрх нь ядуурлын шугамнаас доор амьдарч байна.

Ядуу хэмээн тодорхойлогдсон хүмүүсийн дундаас 0-18 насны хүүхэдтэй (сургууль завсардсан байсан ч ялгаагүй) өрхүүд л зөвхөн хөтөлбөрт хамрагдагсдыг тогтоох загварчилсан судалгаанд хамрагдсан. Үр дүнг нь Хүснэгт 2-т дүрслэв.

Хүснэгтээс үзэхэд хэрэглээний ядууралд тулгуурласан загвартай харьцуулахад ЯЭК нь харьцангуй өргөн хүрээтэй ядуурлын тодорхойлолтыг бий болгож байна. РС загварын хувьд харьцуулалт тийм ч сонирхолтой биш байна. Учир нь хүн амын доод 40 хувь нь ядуу хэмээн тогтоогдсон. Хүснэгтийн хамгийн сүүлчийн эгнээнд сард нэг хүүхдэд 3,000 төгрөг өгвөл жилд нийт хэчнээн төгрөгийг хөтөлбөрт зарцуулах болохыг харуулж байна. Хүүхдийн тоог пропорциональ маягаар шууд шилжүүлсэн тоо боловч томъёоны хувилбар бүрт төсвийн зарцуулалтын том ялгаа байгааг илэрхийлэн харуулж байна.

хэмжээ авахад ашиглагддаг. Үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн үнэлгээ нь хүчин зүйлсийн судалгааны хэсэг бөгөөд хэд хэдэн хувьсагчийн хоорондын хамаарлыг нэг хүчин зүйл болгон "тоймлох" статистикийн арга юм.

⁸ Бусүүдэд тусад нь зориулсан загваруудыг мөн оролдож үзсэн боловч үр дүн нь ялгаагүй байсан.

Хүснэгт 2 Хөтөлбөрт хамрагдагсдын тоог аргачлал тус бүрээр урьдчилан таамагласан байдал

| | ЯЭК | С | С1 | РС ⁹ |
|------------------------------------|---------|---------|---------|-----------------|
| Өрхийн тоо | 223,842 | 106,346 | 119,188 | 212,787 |
| Хүүхдийн тоо | 600,515 | 359,281 | 394,892 | 671,447 |
| Жилд төлөх мөнгө (сая төг.) | 21,619 | 12,934 | 14,216 | 24,172 |

Өрхүүдийн ангилал ба хөтөлбөрийн боловсруулалтын үр нөлөө

Хоёр дахь асуулт нь Хүснэгт 2-т үзүүлсэн аргуудаар ядуу хэмээн урьдчилан тогтоогдоод байгаа хүмүүсийн хичнээн нь өөрсдийн өрхийн хэрэглээний түвшингээр ядууд тооцогдох бол гэсэн асуулт гарна. Энэхүү асуултын хариуг хэд хэдэн графиктай хүснэгт 5-д үзүүлж байгаа юм. График тус бүр хөтөлбөрийн хамрах хүрээг тодорхойлох нэг үзүүлэлтийг илэрхийлж байна. Хэвтээ тэнхлэгт ажиглагдсан хэрэглээ, босоо тэнхлэгт аргачлал тус бүрийн таамаглаж буй нийгмийн халамжийг арга хэмжээг илэрхийлнэ. Хэмжээсүүдийг бүгдийг жигдрүүлсэн бөгөөд 0 цэгээс холдох тусам амьжирганы түвшин дээшилнэ гэсэн үг. Түүнчлэн босоо тэнхлэгийг хэрэглээний ядуурлын шугам дээр зурсан бөгөөд хэвтээ шугамыг аргачлал бүрийн үр дүнд ядуу гэж гарсан өрхүүдийн дунд зурсан. Судалгаанд хамрагдсан өрх тус бүрийг нэг цэгээр илэрхийлсэн бөгөөд судалгааны жин хэрэглээгүй. NE болон SW квадратад байрлаж байгаа өрхүүд (цэнхэрээр будсан) нь өөрсдийнх нь байдлыг томъёогоор зөв илэрхийлсэн хүмүүс гэсэн үг. SE квадратад байгаа улаанаар будсан хүмүүс хөтөлбөрийн хамрах хүрээг тодорхойлох аргачлалаар ядуу хэмээн тогтоогдож байгаа боловч ядуу биш өрхүүд байна. Энэ тайланд хөтөлбөрт хамрагдах ёстой мэтээр гарсан ч хэрэглээг нь ажиглахад ядуу биш гэж гарсан хүмүүсийн хувийг томъёоны хамруулалтын алдаа гэж нэрлэнэ. Эцэст нь NW квадрат дахь ногоон цэгүүд нь хөтөлбөрт хамруулах аргаар ядуу биш гэж гарсан ядуу хүмүүс юм. Ядуу боловч хөтөлбөрт хамрагдахгүй хэмээн алдаатай дүгнэгдсэн хүмүүсийн хувийг хөтөлбөрөөс хасалтын алдаа гэж үзнэ.

Зурагаас харахад бүх аргуудад хамруулалтын болон хасалтын алдаа гаргадаг нь харагдаж байна. Аливаа судалгаанд зайлшгүй гардаг хэрэглээний хэмжээнд алдаа гарсан байж болох учир энэ нь гайхмаар зүйл биш юм. Ядуурлын шугамын ойролцоо байрлаж байгаа өрхүүдийн нэлээд нь төстэй харагдаж байна. Энэ тохиолдолд хөтөлбөрийн хамрах хүрээг тодорхойлох ажилд тухайн шугамны ойролцоо алдаа гарах магадлалтай. Гэхдээ энэ алдаа хэр ноцтой байх нь томъёоноос шалтгаална. Түүнчлэн ХМХ-т тохиолдсон шиг хөтөлбөрт хамрагдах эрхтэй хүмүүсийн шалгуурыг богино хугацаанд хянаж үзэж байхгүй бол улам ноцтой алдаа гарах магадлалтай. Иймэрхүү тохиолдолд хэн ядуу вэ гэдгийг тогтоох арга хэрэгслийг өөрчилснөөр эсвэл ядуурлын үнэлгээний хоорондын зайг өөрчилснөөр хөтөлбөрийн хамрах хүрээг илүү сайн тодорхойлох нь хэцүү байж болох юм. Үүний оронд, ядуурлын шугамны орчимд зааг тогтоож, түүний орчимд хамруулалтын зарим алдааг хүлээн зөвшөөрч болохоор зааж өгөх хэрэгтэй. Хөтөлбөрийн ажилтнууд бүхий л хэсгүүд дээр дурын төлөөлүүлэх аргын томъёогоор хүмүүсийн “үнэн бодитой” ядуурлын байдлыг тогтоох боломжгүй гэдгийг уг хязгаар илэрхийлэх юм. Өөр нэг арга бол хуваарилалтын өөр бүлэгт төвлөрөн ажиллах явдал юм. Жишээ нь “нэн ядуу” хүмүүс байж болох юм. Гэхдээ энэ нь хөтөлбөрийн хувьд улс төрийн өөр тохиролцоонд хүргэж болзошгүй.

⁹ Мексикт хэрэгжсэн Oportunidades зэрэг бусад хөтөлбөрүүдийн жишгээр хөтөлбөрт хамрагдагсдыг тодорхойлохдоо бүрэлдэхүүн индексүүдээр хамгийн доод үзүүлэлттэй 40 хувийг сонгож авсан. Тиймээс нийт тоог нь дараа нь зассан.

Арга тус бүрийн гаргаж буй хамруулалтын алдаа харилцан адилгүй байгаа хэдий ч аргууд ерөнхийдөө ижил төстэй хасалтын алдааг гаргаж байна. Ядуу хүмүүсийн дундаас хэн нь хөтөлбөрт хамрагдаагүй үлдсэнийг ойлгохын тулд 6-р зурагт ядуурлын шугам, нэн ядуурлын шугамыг аль алиныг нь ашигласан квадратуудыг үзүүлж байна. (Хэрэглээний C1 загварыг ашиглан). Эндээс ажиглагдаж буй нэг сонирхолтой зүйл бол энэхүү аргыг ашиглахад хасалтын алдаануудын ихэнх нь нэн ядуу биш харин ядуу өрхүүдийн хувьд гардаг нь харагдаж байна. Хөтөлбөрөөс хасагдсан өрхүүдийн хэрэглээний дундаж үзүүлэлт нь ядуурлын шугамны 80 хувьтай тэнцэж байна. Үүнээс үзэхэд C1 мэтийн томъёо нь нэн ядуучуудыг тогтоохдоо сайн боловч ядуу болон ядууралд ойрхон байгаа өрхүүдийн хооронд сайн ялгаж салгаж чадахгүй байна. Хөтөлбөрт хамрагдаагүй үлдсэн ядуучууд бусдаасаа ямар шинж чанараараа ялгагдаж байгааг үзэхэд тэд гол төлөв хот, суурин газар амьдардаг, зарим талаараа харьцангуй давуу талтай хүмүүс байдаг. (Тухайлбал, орон байрны нөхцөл илүүтэй, боловсрол, хөрөнгө илүүтэй, нийгмийн үйлчилгээнд хүртээмж илүүтэй, ам бүл цөөтэй гэх мэт). Энэ таамаглалыг ул суурьтай шалгаж үзэхэд бидэнд байгаа мэдээлэл хангалттай биш тул тухайн хэсэг дэх ядуучуудын нэлээд олон нь түр зуурын ядуучууд байж болох юм хэмээн тайлбарлаж болох юм.¹⁰ Хэрэв энэ нь үнэн бол ХМХ шиг хөтөлбөрүүд түр зуурын болон байнгын ядуурлын аль алиныг нь бууруулахад чиглэгдэх ёстой, магадгүй түр зуурын ядуурлыг арилгахын тулд өөр хэлбэрийн тусламж үзүүлэх шаардлагатай байж ч болох юм.

Аргуудыг хооронд нь харьцуулахын тулд Хүснэгт 3-т хөтөлбөрт хамрагдагсдын тоог 146,000 өрх буюу ӨАТС дахь 0-18 настай хүүхэдтэй өрхийн тоогоор тогтоосон. Энд хариулах шаардлагатай асуулт нь: хэрэв хүүхэдтэй айлуудын хамгийн ядуу хэсэгт хүрч тусалъя гэвэл ямар арга хамгийн үр дүнтэй байх вэ гэдэг асуулт юм.


Арга тус бүрийн хөтөлбөрийн хамрах хүрээг хэр оновчтой тогтоож чадаж байгааг шүүхэд дараах шалгууруудыг тавьсан: (а) тусламжид хамрагдагсдын дотор ядуу хүмүүсийн эзлэх хувь; (б) тусламжид хамрагдагсдын дотор ядуу биш хүмүүсийн эзлэх хувь; (в) ядуу боловч хөтөлбөрт хамрагдаагүй хүмүүсийн хувь; (г) тусламжид хамрагдагсдын доторх нэн ядуу хүмүүсийн эзлэх хувь; (д) нэн ядуу боловч хөтөлбөрт хамрагдаагүй хүмүүсийн хувь.

Хүснэгт 3-т эдгээр асуултын хариуг нэгтгэн тавьсан (хүн амын эзлэх хувийн жинг тогтоосон). Тод хараар үзүүлэлт (эгнээ) тус бүрийн хувьд бусадтайгаа харьцуулбал давуу талтай аргыг тэмдэглэсэн. Хүснэгтээс үзэхэд хэрэглээнд тулгуурласан аргууд (C and C1) нь нөгөө хоёр аргатайгаа¹¹ харьцуулахад нэн ядуу хүмүүст хүрэх тал дээр илүү байгаа нь харагдаж байна. Түүнчлэн, хамруулалт, хасалтын алдаанууд эдгээр аргын хувьд цөөхөн ажиглагдаж байна.


¹⁰ Түр зуурын ядууралд байгаа хүмүүс гэдэг нь аливаа цаг зуурын хүндрэлд орсон, түүнийгээ даван туулж чадах хүмүүсийг хэлнэ. Энэ бүлгийнхэн байнгын ядуу буюу емч, хөрөнгө муутай, ирээдүйд ядуурлаас гарах магадлал тун багатай ядуучуудаас ялгаатай.

¹¹ 2000 онд хэрэгжүүлсэн "Oportunidades" хөтөлбөрийн үнэлгээний явцад Скоуфиас болон түүний хамтран ажиллагсадын олж тогтоосноор тус хөтөлбөр 25 хувийн хасалтын алдаатай, 40 хувийн хамруулалтын алдаатай байсан. (Скоуфиас Е. ба бусад, Прогреса дахь Хөтөлбөрт хамрагдах өрхүүдийг сонгох үйл явцын үнэлгээ, in "Prograsa: M6s Oportunidades par las Familias Pobres", Mexico, 2000).

Зураг 5 Хөтөлбөрт хамрагдагсдыг тодорхойлох аргуудыг өрхүүд хэрхэн ангилсныг харьцуулсан байдал



Зураг 6 С1 Хэрэглээний загварт үндэслэн ядуу болон нэн ядуу өрхүүдийг буруу тогтоосон байдал



Хүснэгт 3 Хөтөлбөрийн боловсруулалтын алдаа (Хамгийн ядуу, 146,000 хүүхэдтэй өрх)

| | ЯЭК | С | С1 | РС |
|--------------------------------------|--------|--------|---------------|--------|
| Ядуурал | | | | |
| Ядуу хамрагдагсад | 85,500 | 90,000 | 95,000 | 79,000 |
| % ядуусын эзлэх хувь | 62% | 64% | 67% | 54% |
| % ядуу биш хүмүүсийн эзлэх хувь | 38% | 36% | 33% | 46% |
| % хөтөлбөрийн гадна үлдсэн ядуус | 42% | 38% | 35% | 45% |
| Нэн ядуурал | | | | |
| Нэн ядуу хамрагдагсад | 28,000 | 32,000 | 33,900 | 25,000 |
| % нэн ядуусын эзлэх хувь | 20% | 23% | 23.7% | 17% |
| % хөтөлбөрийн гадна үлдсэн нэн ядуус | 27% | 17% | 11.7% | 34% |

Ямар ч томъёогоор хүмүүсийн амьжиргааны түвшинг тодорхойлоход их бага хэмжээний алдаа гарч болох тул хөтөлбөрийн алдаануудыг илүү ул суурьтай авч үзэх шаардлагатай. Хөтөлбөрт хамрагдагсдыг тодорхойлох томъёогоор буруу ангилагдсан өрхүүд өрхийн зардлын үзүүлэлтээрээ хаана байгааг Хүснэгт 4-өөс нарийвчлан харж болно. Хөтөлбөрт алдаатай хамруулсан ихэнх тохиолдлууд ядуурлын шугамны дөнгөж дээгүүр байгааг харж болно. Энэ нь хэрэглээний С1 загвараас улам бүр тодорхой харагдаж байна. Хүснэгтээс харахад энэхүү арга нь хөтөлбөрийн гадна үлдэх нэн ядуус буюу ядуурлын шугамнаас хамгийн хол байгаа ядуу хүмүүсийн тоог хамгийн бага байлгаж чадаж байгаа юм. ЯЭК-ын загвар нь энэ тал дээр илүү учир дутагдалтай байгаа бөгөөд РС загвартай илүү ойр байгаа юм. Тиймээс хөтөлбөрийн хамрах хүрээг тогтоох үйл явцын учир дутагдлыг ухамсарласны үндсэн дээр алдаа гарахыг тодорхой хэмжээгээр хүлээн зөвшөөрч хязгаарыг тогтоож өгвөл С1 загвар бусдыгаа бодвол илүү давуу талтай бөгөөд ЯЭК-той харьцуулбал илүү үр дүнд хүргэж болохоор санагдаж байна.

Хүснэгт 4 Хөтөлбөрт хамруулах, үл хамруулах ажилд гарсан алдаа (Хамгийн ядуу 146,000 хүүхэдтэй өрх)

| | ЯЭК | С | С1 | РС 46% |
|---|------------|------------|------------|-------------------|
| ХАМРУУЛСАН | 38% | 36% | 33% | |
| Тэдгээрээс ядуу биш боловч тусламжид хамрагдсан ... | 29% | 33% | 39% | |
| ядуурлын шугамнаас 20% хүртэлх хувиар дээр, ядуурлын шугамнаас >20-50% дээр, ядуурлын шугамнаас >50-100% хувиар дээр, ядуурлын шугамнаас >100% хувиар дээр | 34% | 34% | 33% | |
| | 21% | 22% | 21% | |
| | 16% | 11% | 21% | |
| ҮЛ ХАМРУУЛСАН | 42% | 38% | 35% | |
| Тэдгээрээс ядуу боловч тусламжид хамрагдаагүй ... | 24% | 28% | 31% | |
| ... ядуурлын шугамнаас 10% хүртэлх хувиар доор, ядуурлын шугамнаас >10-20% хувиар доор, ядуурлын шугамнаас >20-30%, ядуурлын шугамнаас хувиар доор >30% хувиар доор | 22% | 21% | 24% | |
| | 19% | 22% | 21% | |
| | 35% | 29% | 21% | |

4. Зөвлөмжүүд

Хөтөлбөрт хамрагдагсдыг тодорхойлох томъёог боловсронгуй болгох

Хүүхдийн мөнгөний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Ядуурлын эрсдлийн коэффициентийг үнэн зөвөөр ашигласан тохиолдолд хөтөлбөрт хамрагдахаар тооцогдож байсан өрхийн тооноос даруй 35 хувиар илүү өрх тус хөтөлбөрийн хэрэгжилтийн эхний жилд хамрагдсан нь засаг захиргааны баримт мэдээллээс харагдаж байна. Энэхүү тооны хичнээн хувь нь хэрэгжилтийн алдаанаас үүдэлтэй, хичнээн хувь нь хөтөлбөрийн боловсруулалтын алдаанаас үүдэлтэй болохыг ялгаж салгахад хэцүү ч тус хөтөлбөрт нэлээн ноцтой доголдол байгаа нь илэрхий байна. Хэрэв хөтөлбөрийн хэрэгжилт алдаа магадгүй явагдсан байсан бол хөтөлбөрт хамрагдах ёстой өрхийн тоо 35 хувиар илүү байсан гэсэн үг бөгөөд энэ нь хэрэгжилтийн асуудлаас үүдэлтэй гэсэн үг. Хөтөлбөрт хамрагдагсдыг тогтооход одоо ашиглаж буй томъёоны нарийвчлал хангалтгүй байгаа учраас хөтөлбөрийн хэрэгжилт ямар ч алдаагүй явагдсан байлаа ч хөтөлбөрт одоо хамрагдаад байгаа өрхүүдийн 36-62 хувь нь ядуу биш байх магадлалтай гэдэг нь анхаарвал зохих асуудал болж байна. Үүнээс үзэхэд ХМХ-т хамрагдагсдыг тогтоох үйл явцад гарц буй алдаануудыг ойрын хугацаанд залруулах шаардлагатай нь харагдаж байна.

Дээрх дүгнэлтээс үзэхэд ХМХ-т хамрагдагсдыг тодорхойлох томъёог сайжруулах хэрэгтэй нь харагдаж байна. Юуны өмнө томъёог хялбарчилж, түүнийг ашиглахад илүү дөхөмтэй болгох хэрэгтэй. Хоёрдугаарт томъёог сольж, хөтөлбөрт хамрагдагсдын тоог цөөрүүлэх өөр томъёогоор орлуулж, ингэснээрээ хөтөлбөрийг санхүүгийн хувьд илүү тогтвортой болгож, түүнчлэн тус хөтөлбөрөөс олгох мөнгөн тусламжийн бодит үр нөлөөг ирээдүйд тогтвортой түвшинд байлгах нөхцлийг хангаж болох юм. Гуравдугаарт, хөтөлбөрт хамруулах эсвэл үл хамруулахад тохиолдох алдааг бууруулахын тулд өөр томъёо ашиглах нь илүү байж магадгүй. Эцэст нь хэлэхэд нэн ядуучуудын хөтөлбөрт хамрагдах бололцоог дээшлүүлэхийн тулд нэмэлт шалгууруудыг оруулж өгөх шаардлагатай. Гэхдээ тус томъёог

сайжруулахын тулд чухам юу хийх шаардлагатай байна вэ?

- a. Байгаа мэдээлэлд тулгуурлан уг томъёог одоо түүнд орж буй хувьсагчдыг багтаасан хэрэглээнд үндэслэсэн тэгшитгэлээр сольж болох юм. Хувьсагчдын бүлэг нь хэрэглээн дэх ялгааг тайлбарлахад хэрэгтэй байх болно. Ийм томъёо нь тус судалгаанд ашиглагдаж буй хэрэглээний С загварын үзүүлэлтэд тулгуурласан мэт харагдаж болохыг Хавсралт 3-т дүрсэлсэн байна. Энэхүү хүснэгт нь Хавсралт 2-т үзүүлсэн одоогийн ашиглагдаж буй хүснэгтийн бараг хагастай нь тэнцүү бөгөөд нэлээн хялбаршуулсан хувилбар гэдгийг дурдах нь чухал юм. Хавсралт 3 дахь хүснэгтэд байгаа шиг коэффициент нь хэрэглээний түвшинг таамаглаж тогтооход ашиглагдах бөгөөд ядуурлын шугам нь зааглах шалгуур үзүүлэлт болно. Энэ нь одоо ашиглаж буй аргаас давуу талтай бөгөөд (энэ нь хөтөлбөрт хамрагдагсдын тоог мэдэгдэхүйц хэмжээгээр багасгаж, хөтөлбөрийг илүү сайн чиглүүлж, хэрэгжилтийг хялбарчилна) харьцангуй бага зардлаар хэрэгжүүлэх боломжтой.
- б. Хэдийгээр ХМХ нь харьцангуй шинэ хөтөлбөр боловч хөтөлбөрт хамрагдагсдын дунд хүүхдийн мөнгийг тэд авах эрхтэй гэсэн сэтгэгдэл хэдийнэ бүрэлдээд байна. Иймээс, хамрагдагсдын хүрээг өөрчлөх аливаа арга хэмжээ нь хөтөлбөрт хамрагдаж буй өрхүүдийн нэлээдийг хасах тул хүмүүст таалагдахгүй байж магад. Олон улсын туршлагаас харахад иймэрхүү өөрчлөлтийг хийх улс төрийн боломж нь нэн ядуучууст хүрэхэд чиглэсэн үзүүлэлтүүд хэр зэрэг ил тод, итгэл төрүүлэхүйц байгаагаас шалтгаалдаг. Мөн түүнчлэн иймэрхүү шинэчлэлийг аажмаар хэрэгжүүлэх нь ач холбогдолтой байдаг нь нотлогдсон.
- в. Бидний судалгаанаас үзэхэд С1 загварт ашигласан шиг нэмэлт мэдээлэл, тоо баримтыг ашиглавал ХМХ-т хамрах хүрээг тодорхойлох ажил улам нарийвчлалтай, боловсронгуй болох нь харагдсан. Хөтөлбөрт одоогоор хамрагдаад байгаа хүмүүсийн талаар нэмэлт мэдээлэл цуглуулахад нэг зардал их гарахгүй. Учир нь хөтөлбөрт хамрагдагсад тэтгэмжээ авахаар хөтөлбөрийн байраар ирэхэд нь мэдээллийг авах боломжтой юм. Одоо байгаа мэдээлэл дээр нэмж дараах мэдээллийг авч болох юм. Үүнд: (i) өрхийн тэргүүн, эхнэр, нөхрийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл; (ii) тухайн өрх нийтийн үйлчилгээнд хамрагддаг эсэх; (iii) байр, орон сууцны талаарх нэмэлт мэдээлэл; (iv) өмчийн эзэмшил зэрэг юм. Хавсралт 4-т Мексикт хэрэгжүүлсэн “Oportunidades” хөтөлбөрт хамрагдах хүмүүсийг тодруулах зорилгоор ямар мэдээлэл цуглуулсныг үзүүлэв. Хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй хүмүүсээс энэ бүх мэдээллийг цуглуулснаар бүх хувьсагчид нь аргын томъёонд ордог гэсэн үг биш юм. Өөрөөр хэлбэл энэ бүх мэдээлэл хөтөлбөрийн хамрах хүрээг тодорхойлох томъёонд орох албагүй тул илүү мэдээлэл цуглуулснаар томъёо илүү ярвигтай болдоггүй. (Мексикийн жишээнд хувьсагчдын бүлэг л томъёонд ордог). Гэхдээ энэ нэмэлт мэдээллийг авснаар хөтөлбөрийн хамрах хүрээг тодорхойлох томъёог орон нутгийн онцлогт тохируулж, ашиглахад илүү уян хатан болгодог. Түүнчлэн, хэдий чинээ олон төрлийн мэдээлэл цуглуулна, хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй хүмүүс хамрагдахын тулд худал хариулт өгөх боломж төдий чинээ хязгаарлагдана.

ХМХ-ийн төлөвлөлт, хэрэгжилтийг боловсронгуй болгох

Өнөөг хүртэл цуглуулсан баримтаас үзэхэд ХМХ-т хамрагдагсдын тоо ийнхүү хурдан өсөж байгаа нь тус хөтөлбөрийн цаашдын санхүүгийн тогтвортой байдалд аюул учруулж магадгүй байдал ажиглагдаж байна. Түүнчлэн хөтөлбөрийн

төлөвлөлт болон түүний хамрах хүрээг тодорхойлох томъёог сайжруулж, ингэснээр хөтөлбөр ядуу болон нэн ядуу хүмүүст хүрч ажиллах, хөтөлбөрт хамруулах, хасахад гарах алдааг хамгийн бага байлгах нөхцлийг хангаж ажиллах хэрэгтэй. Ядуурлын эрсдлийн коэффициентыг гажуудуулалгүй хэрэглэсэн бол тус коэффициент ямар үр дүнд хүргэх байсан нь судалгааны загваруудаас харагдаж байна. Түүнчлэн тус загварууд нь хөтөлбөрийн хамрах хүрээг өргөн байна гэж тооцоолсон бөгөөд хөтөлбөрт хамрагдагсдын зүгээс хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлөхүйц ямар зан үйлдэл гаргаж болохыг тооцоогүй болно. Гэхдээ хөтөлбөрийн хамрах хүрээг тогтоох томъёог хичнээн сайжрууллаа ч гэсэн хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнтэй, уян хатан механизм, хяналт, үнэлгээний сайн тогтолцоо байгаа тохиолдолд л тус хөтөлбөр амжилттай хэрэгжих болно гэдгийг онцлон хэлэх хэрэгтэй. Дэлхийн банк нь Монгол Улсын Засгийн газартай бодлогын яриа хэлцэл хийх явцдаа ХМХ-ийн боловсруулалт, хэрэгжилтийг сайжруулах талаар энд дурдагдсан асуудлуудыг хөндөж тавьсан бөгөөд энэ хэсэгт авч үзэж байгаа юм. Нөгөө талаас, хөтөлбөрийг боловсруулахтай холбоотой хоёр асуудлыг цаашид улам боловсронгуй болгож болно. Нэгд, 8-13 насны хүүхдүүдийн хамран сургалт 90 хувьтай байгаа тул ХМХ нь үүнд сайнаар нөлөөлөх бололцоо хязгаарлагдмал байна. Ийм учраас ХМХ нь өрхийн хүүхдийнхээ боловсролд оруулах хөрөнгө оруулалтанд хувь нэмэр болох зорилгыг агуулж байгаа бол хүүхдээ сургуульд хамруулах болзлыг тавьж, хэрэгжилтийг нь хянах хэрэгтэй. Одоогоор ийм болзол байхгүй байгаа. Эсвэл сургууль завсардалт их тохиолддог бага ангиас дунд ангид шилжих ангиудад анхаарал хандуулах хэрэгтэй.

Бас нэгэн анхаарал татсан асуудал бол ХМХ нь ядуучуудад тусламж үзүүлэх эсвэл ерөнхийдөө сургуулийн хамрагдахыг нэмэгдүүлэх зорилготой юу гэдгийг тодорхойлох явдал юм. Хэрэв зорилго нь хамран сургалтыг нэмэгдүүлэх явдал бол хөтөлбөрт хамрагдахад тавих шалгууруудыг илүү нарийвчилж, боловсронгуй болгох шаардлагатай. Жишээлбэл, бага сургуулийн хамран сургалт нэгэнт өндөр байгаа тохиолдолд тус хөтөлбөрийг өөр насны хүүхдүүдэд чиглүүлж болох юм. Гэхдээ тус хөтөлбөр нь үр ашгаа хэнд өгөх вэ, ядуучуудад хэр хүрч чадах вэ гэдгийг бодох хэрэгтэй. Эдгээр асуудлууд бүгд чухал боловч энэхүү тайланд дэлгэрэнгүй авч үзээгүй болно. Хөтөлбөрт бодитоор хамрагдаж байгаа хүмүүс, тэдгээрийн зан үйлийн мэдээллийг нэмж авсан тохиолдолд дээр дурдсан зарим асуултуудад илүү тодорхой хариулт өгч болох юм.

Хоёр дахь асуудал нь тэтгэмжийн хэмжээтэй холбоотой юм. Өрхүүд хүүхдийнхээ эрүүл мэнд, боловсролд илүү анхаарах зан үйлийг төлөвшүүлж чадахуйц хэмжээний мөнгийг өгч чадаж байна уу гэдгийг тодруулах шаардлага гарч ирнэ. Одоохондоо энэ асуултанд хариулт алга. Үүнээс гадна ХМХ-ийг ямар ч туршилт, хяналт үнэлгээний стратегигүйгээр улс орон даяар шууд хэрэгжүүлж эхэлсэн учир иймэрхүү асуудлуудын талаар мэдээлэл байхгүй байна.

Ядуучуудад чиглэх зорилгоо ХМХ нь хэрхэн биелүүлж байгаад шууд нөлөөлөх бас нэг хэсэг асуудал бол тус хөтөлбөрийн үйл ажиллагаа, зохион байгуулалттай холбоотой асуудлууд юм. Энд бас яригдах нэг асуудал бол хөтөлбөрт хамрагдах эсэхийг шийдэх хоёр үе шаттай үйл явцыг эргэж хянах шаардлага байна. Учир нь орон нутгийн засаг дарга нар болон хөтөлбөрийн ажилтнууд шийдвэр гаргахдаа өөрсдийн үзэмжээр шийдэх боломж ихтэй байдаг. Түүнчлэн орон нутгийнхаа засаг даргаас тодорхойлолт авч чадаагүй хүмүүс хөтөлбөрт хамрагдахад шаардлагатай оноогоо авч чадахгүйд хүрдэг. Иргэдийг ХМХ-т хамрагдах эсэх шийдвэр гаргахад Засаг дарга нарыг оруулдаггүй болгох хэрэгтэй. Гэхдээ онцгойлон үзэх шаардлагатай тохиолдол, эсвэл гэнэтийн тохиолдлын улмаас өрхийн амьжиргаанд өөрчлөлт гарах зэрэг тохиолдолд хөтөлбөрт хамрагдах эсэхийг эргэн харах боломжийг олгож байх хэрэгтэй.

ХМХ-ийн хэрэгжилттэй холбоотой Дэлхийн банкнаас илрүүлсэн бас нэгэн асуудал нь төлөөлүүлэх аргын оноог зөв тогтоож байгаа эсэхийг хянах механизм байхгүй байна. Хүмүүсийн яриа, орон нутагт хийсэн ажиглалтаас үзэхэд төлөөлүүлэх аргын оноог тогтооход ашиглагддаг үзүүлэлтүүдийг сайн мэдэж буй айл өрхүүд эсвэл хөтөлбөрийн ажилтнууд хөтөлбөрийн хамрах хүрээг тодорхойлох томъёоны үр дүнд нөлөөлдөг нь харагдсан. Бусад жишээнээс үзэхэд оноог тогтоох үнэлгээг хийдэг хөтөлбөрийн ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх, сургах ажил хангалтгүй байснаас хөтөлбөрт хамрагдагсдыг тогтоох ажилд алдаа гардаг байж болох талтай. Хариуцлагын тогтолцоо сул байгаа бөгөөд хөтөлбөрийн дүрэм журмын хэрэгжилт зөв явагдаж байгаа эсэхийг хянах механизм байхгүй байгаа нь хөтөлбөрийн хамрах хүрээг тогтоох ажилд сөргөөр нөлөөлж болно. Үүнээс гадна хөтөлбөрт хамрагдах хүсэлтэд татгалзсан хариу авсан хүмүүсийн бүртгэлийг хөтөлбөрийн ажилтнуудад хадгалагддаг эсэхэд ямар ч хяналт тавьдаггүй.

Хөтөлбөрийн үйл ажиллагаатай холбоотой бас нэг бэрхшээл нь хөтөлбөрийн хяналт, үнэлгээг явуулах арга хэрэгсэл дутагдаж байгаа явдал юм. Жишээлбэл, хэн мөнгөө авсан, хэзээ авсаныг хүн нэг бүрээр бүртгэсэн бүртгэл байдаггүй. Засгийн газарт өгдөг бүх тоо баримт нь нэгтгэсэн ерөхий тоо байдаг. Түүнээс гадна ХМХ-ийн зүгээс тавьдаг болзлуудыг эцэг, эхчүүд даган мөрдөж байгаа эсэхийг албан ёсоор хянах механизм байдаггүй. Түүнчлэн хичээлийн жилийн дундаас сургууль завсардаж байгаа хүүхдүүдийг тогтоохын тулд хамран сургалтыг тогтмол хянах, бага насны хүүхдүүдийг вакцинд хамруулж байгаа эсэхийг хянах ажил орхигдож байна. Мөн хөтөлбөрт хамрагсад нь мөнгө авахад тавьдаг болзлуудыг хангаж байгаа эсэхийг тогтмол хянадаггүй байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл ажиллагаатай холбоотой бас нэгэн асуудал бол хөтөлбөрт хамрагдагсдад учирч буй зардлыг бууруулахтай холбоотой асуудал юм. Ядуу иргэд гол төлөв илүү алслагдмал нутагт амьдарч, хөтөлбөрт бүртгүүлэх, мөнгөө байнга авахад илүү зардал гаргах магадлалтай байдаг. Тиймээс мөнгөө авах механизмыг уян хатан болгож, хүмүүсийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэх шаардлагатай. Одоогийн байдлаар хүүхдийн мөнгийг Хөдөө аж ахуйн банкны ажилтнуудаар дамжуулан олгож байна. Гэхдээ өндөр насны тэтгэвэрийг олгоход тогтсон аргыг өөрөөр хэлбэл иргэдийн банкны дахь мөнгийг шилжүүлдэг аргыг ХМХ-т нэвтрүүлж болох талтай. Ингэснээр хүүхдийн мөнгө авагчид өөрийн дансанд орсон мөнгийг авах хугацаагаа хойшлуулбал хүүг нь авах боломжтой юм. Түүнчлэн энэ нь өрхүүдэд уг мөнгөний зарим хэсгийг хадгалах сонирхол бий болж болох бөгөөд цаашдаа банк, санхүүгийн бусад үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлэх магадлалтай.

Эцэст нь хэлэхэд ядуучууд, тэдний дотор шилжин суурьшигчид, алслагдмал нутагт амьдарч буй иргэд гэх мэт хүмүүсийн хөтөлбөрт хамрагдахад шаардлагатай бичиг баримт нь (ялангуяа хүчинтэй иргэний үнэмлэх) бэлэн байдаггүй. Энэ асуудлыг ядуурлын судалгаанд онцлон тэмдэглэсэн. Шилжин суурьшигчид, алслагдмал нутагт оршин суугчид нь баримт бичгийн шилжүүлэг хийлгэх хураамж өндөр байдгаас оршин суугаа дүүрэгтээ тэр болгон албан ёсоор бүртгүүлдэггүй байна. Тус тайлангаас хөдөө орон нутагт иргэний бүртгэлийн явууллын цэг ажлуулж, ядуу, алслагдмал нутгийн иргэдэд иргэний бичиг баримтыг үнэ төлбөргүй олгох кампанит ажлыг орон даяр өрнүүлэх зөвлөмж гаргасан.

Хавсралт 1: ХМХ Засаг захиргааны тоо баримт болон 2000 оны тооллогын хувьсагчид

| | Хамрагдсан хүүхдүүд / 2000 оны хүн ам | 11 сар – 6 сарын хоорондох өсөлтийн % | | Өрхийн дундаж хэмжээ | Цэвэр шилжин суурьшилт/ хүн ам | Боловсролгүй хүн амын эзлэх хувь | Хөдөөгийн хүмүүсийн эзлэх хувь |
|-------------|--|---|--------|----------------------------|--------------------------------------|--|--------------------------------------|
| | | Өрх | Хүүхэд | | | | |
| Архангай | 0.32 | 1.47 | 0.63 | 4.00 | -0.38 | 19.77 | 80.93 |
| Баян-Өлгий | 0.42 | 0.56 | 0.30 | 4.70 | -0.10 | 18.64 | 69.19 |
| Баянхонгор | 0.32 | 1.57 | 0.62 | 4.10 | -0.27 | 21.30 | 73.97 |
| Булган | 0.29 | 2.64 | 1.07 | 4.00 | -0.23 | 17.95 | 73.71 |
| Говь-Алтай | 0.34 | 1.71 | 0.75 | 4.30 | -0.50 | 19.17 | 71.69 |
| Говьсүмбэр | 0.26 | 2.40 | 0.93 | 4.00 | 0.53 | 17.12 | 26.55 |
| Дархан | 0.27 | 4.21 | 1.14 | 4.20 | 0.40 | 15.08 | 20.99 |
| Дорноговь | 0.18 | 1.61 | 0.71 | 4.00 | -0.06 | 17.51 | 50.15 |
| Дорнод | 0.55 | 2.37 | 3.76 | 4.30 | -0.08 | 19.76 | 44.66 |
| Дундговь | 0.26 | 1.40 | 0.61 | 4.20 | -0.25 | 21.11 | 71.82 |
| Завхан | 0.28 | 1.84 | 0.77 | 4.10 | -0.48 | 18.68 | 73.03 |
| Орхон | 0.26 | 2.46 | 1.26 | 4.10 | 0.64 | 14.89 | 4.49 |
| Өвөрхангай | 0.26 | 6.31 | 0.50 | 4.10 | -0.21 | 21.55 | 82.90 |
| Өмнөговь | 0.28 | 1.50 | 0.71 | 3.90 | -0.15 | 19.86 | 69.73 |
| Сүхбаатар | 0.28 | 1.84 | 0.80 | 4.30 | -0.26 | 22.30 | 73.06 |
| Сэлэнгэ | 0.42 | 4.91 | 1.82 | 4.30 | 0.15 | 16.93 | 43.53 |
| Төв | 0.15 | 1.20 | 0.61 | 4.10 | -0.10 | 18.26 | 83.65 |
| Увс | 0.28 | 0.84 | 0.13 | 4.40 | -0.40 | 20.73 | 70.77 |
| Ховд | 0.33 | 0.66 | 0.17 | 4.70 | -0.28 | 19.73 | 70.03 |
| Хөвсгөл | 0.35 | 2.12 | 0.98 | 4.10 | -0.20 | 18.78 | 73.55 |
| Хэнтий | 0.27 | 2.10 | 0.97 | 4.00 | -0.10 | 19.58 | 60.74 |
| Улаанбаатар | 0.18 | 2.52 | 1.25 | 4.60 | 0.31 | 12.03 | 0.00 |

Хавсралт 2: ЯЭК-ын загварчлалд орсон хувьсагчид

| ХМХ-ийн ЯЭК дэх хувьсагчид - Хот хөдөөгөөр | | Загварчлалд ороогүй |
|--|--|--|
| 1 | Байршил | |
| | Улаанбаатар | |
| | Аймгийн ¹² төв | |
| | Сумын төв | |
| | Хөдөө | |
| | Өрхийн ам бүл | |
| | 1 | |
| | 2 | |
| | 3 | |
| | 4 | |
| 2 | 5 | |
| | 6 | |
| 3 | 7 | |
| | 8 буюу түүнээс дээш | |
| 3 | Боловсролын түвшин | |
| | Дээд | |
| | Дипломын түвшний дээд боловсрол (техникийн коллеж) | |
| | Мэргэжлийн | |
| | Бүрэн дунд (10 жил) | |
| | Бүрэн бус дунд (8-р анги) | |
| | Бага | |
| Боловсролгүй | | |
| 4 | Хөдөлмөр эрхлэлт | |
| | Төсвийн байгууллага | Төрийн байгууллага, улсын үйлдвэрийн газар |
| | Төрийн өмчийн үйлдвэрийн газар | |
| | Хувийн бизнесийн компаний эзэн | |
| | Хувийн компанид ажилтан | |
| | Малчин | |
| | Газар тариаланч | |
| | Албан бус салбарын ажилтан | Х |
| | Олон улсын байгууллага | Х |
| | Төрийн бус байгууллага | Х |
| | Түр зуурын эсвэл улирлын чанартай ажил | Х |
| | Цэргийн албан хаагч | Х |
| | Тэтгэвэрт | |
| | Ажилгүй | |
| | Хөдөлмөрийн чадваргүй | Х |
| | | Ажиллах хүчнээс хамрагддаггүй |

¹² Аймаг нь дүүрэгтэй дүйхүйц засаг захиргааны нэгж юм.

Хавсралт 2 - үргэлжлэл

| ХМХ-ийн ЯЭК дэх хувьсагчид - Хот хөдөөгөөр | | Загварчлалд ороогүй |
|---|---|----------------------------------|
| 5 | Орон байрны нөхцөл | |
| | Гэр | |
| | Тохилог сууц | Байшин |
| | Орон сууц | |
| | Нийтийн байр | X |
| | Хөлсний байр | X |
| | Зориулалтын бус байр | X |
| | Орон сууцны коридор | X |
| | | Бусад |
| 6 | Хөрөнгө | |
| | Мөнгөн хөрөнгө | хадгаламж |
| | Мал (4-өс дээш (бод малаар)) | X |
| | Газар /(орлого оруулж буй) | X |
| | Дэлгүүр, ТҮЦ | X |
| | Зоогийн газар, цайны газар хувийн | X X |
| | Дээрх зүйлсийн 2 буюу түүнээс дээш | X |
| | Дээрх зүйлсийн 3-аас дээш | X |
| | Дээрхийн аль нь ч үгүй | X |
| 7 | Орлого олдог гишүүдийн тоо | |
| | 1 | |
| | 2 | |
| | 3 | |
| | 4-өөс илүү | |
| | Орлого олдог гишүүн байхгүй | |
| | Мал | |
| | 4-өс цөөн | |
| | 5-10 | |
| | 11-20 | |
| | 21-30 | |
| | 30-50 | |
| | 50-иас олон | |
| | Малгүй | |
| | 8 | Тээврийн хэрэгсэл эзэмшил |
| Машин | | |
| Мотоцикл | | |
| Трактор | | |
| Тэрэг (морин тэрэг, үхэр тэрэг, тэмээн тэрэг) | | X |
| Тээврийн хэрэгсэл байхгүй | | |
| 9 | Тусгай тусламж, тэтгэлэг | |
| | Нийгмийн тусламжийн сангаас тусламж авдаг | X |
| | ТББ-аас тусламж авдаг | X |
| | Хамаатан садан, бусад хүмүүсээс тусламж авдаг | X |
| | Гадаадаас тусламж авдаг | X |
| | Тусламж авдаггүй | X |

Хавсралт 2 - үргэлжлэл

| ХМХ-ийн ЯЭК дэх хувьсагчид - Хот хөдөөгөөр | | Загварчлалд ороогүй |
|--|---|---------------------|
| 10 | Тахир дутуу эсвэл хөгжлийн бэрхшээлтэй гишүүд | |
| | <i>Яриа, сонсголын согогтой</i> | X |
| | <i>Хараа муу (хараагүй)</i> | X |
| | <i>Бие махбодийн хувьд тахир дутуу /тэргэнцэртэй эсвэл таяатай явдаг/</i> | X |
| | <i>Оюуны хомсдолтой</i> | X |
| | <i>Хэвтрийн /асаргаа шаардлагатай/</i> | X |
| | <i>Дээрхээс хоёр нь</i> | X |
| | <i>Дээрхээс гурав нь</i> | X |
| | <i>Аль нь ч байхгүй</i> | |
| 11 | Өрхийн эмзэг байдал | |
| | <i>Архичин</i> | X |
| | <i>Өндөр настан (70 түүнээс дээш настай)</i> | X |
| | <i>өнчин</i> | X |
| | <i>4 буюу түүнээс дээш хүүхэдтэй ганц бие хүн</i> | X |
| | <i>Ганц бие өндөр настан</i> | X |
| | <i>Дээрхийн хоёр нь</i> | X |
| | <i>Дээрхээс гурав нь</i> | X |
| | <i>Дээрхийн аль нь ч биш</i> | X |

Хавсралт 3: Хөтөлбөрт хамрагдагсдыг тодорхойлох томъёог хялбарчлах нь– жишээ

| | Хотын индекс | Хөдөөгийн индекс |
|---|--------------|------------------|
| Байрлал | | |
| Улаанбаатар | .0950 | - |
| Сумын төв | - | .1290 |
| Өрхийн тэргүүний нас | | |
| 25-34 | -.0537 | -.0946 |
| 45-54 | .0969 | - |
| 55 түүнээс дээш | .0877 | - |
| Өрхийн ам бүл | | |
| 2 | -.4111 | -.5703 |
| 3 | -.7571 | -.8022 |
| 4 | -.9196 | -1.002 |
| 5 | -1.072 | -1.211 |
| 6 | -1.259 | -1.335 |
| 7 | -1.378 | -1.495 |
| 8 түүнээс дээш | -1.618 | -1.620 |
| Боловсролын түвшин | | |
| Дипломын түвшний дээд боловсрол (техникийн | .5326 | .2613 |
| Мэргэжлийн | .4127 | .0943 |
| Бүрэн дунд (10 жил) | .3132 | - |
| Бүрэн бус дунд (8-р анги) | .3790 | .0934 |
| Бага | .1911 | .0679 |
| Боловсролгүй | .1627 | - |
| Дипломын түвшний дээд боловсрол (техникийн коллеж) | | |
| Төсвийн байгууллага, улсын үйлдвэрийн газар | .0999 | .1666 |
| Хувийн бизнесийн байгууллагын эзэн, хувиараа бизнес эрхлэгч | .1553 | .0993 |
| Хувийн компаний ажилтан | .0682 | - |
| Газар тариаланч | - | -.1326 |
| Тэтгэвэрт | - | .0631 |
| Ажилгүй | .1158 | .1362 |
| Ажиллах хүчинд хамрагдаггүй | .0631 | - |

Хавсралт 3 үргэлжлэл

| | Хотын индекс | Хөдөөгийн индекс |
|---|-----------------|---------------------|
| Орон байрны нөхцөл | | |
| <i>Байшин</i> | .0865 | - |
| <i>Орон сууц</i> | .1974 | .1200 |
| <i>Бусад (байшин, орон сууц, гэрээс бусад)</i> | - | .4610 |
| Өмч хөрөнгө | | |
| <i>Хадгаламж</i> | -.1259 | - |
| Гэр бүлийн орлоготой гишүүд | | |
| <i>1</i> | .0927 | - |
| <i>2</i> | .2529 | .1565 |
| <i>3</i> | .2434 | .0964 |
| <i>4-өөс илүү</i> | .4058 | .0989 |
| Мал | | |
| <i>4-өөс цөөн</i> | - | -.1035 |
| <i>5-10</i> | - | .0655 |
| <i>11-20</i> | - | -.2804 |
| <i>21-30</i> | - | .2651 |
| <i>30-50</i> | - | .3395 |
| <i>50-иас илүү</i> | - | .4923 |
| Тээврийн хэрэгсэл | | |
| <i>Мотоцикл</i> | -.2173 | -.1904 |
| <i>Тээврийн хэрэгсэл байхгүй</i> | -.3594 | -.2804 |
| Гэр бүл дэх тахир дутуу, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс | | |
| <i>Тахир дутуу хүн байхгүй</i> | -.0692 | .0529 |

Хавсралт 4: Мексикт хэрэгжүүлсэн “Oportunidades” хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргагсдаас цуглуулсан мэдээлэл (эдгээр хувьсагчдаас хэрэглээг хамгийн сайн илэрхийлж чадах үзүүлэлтүүдийг сонгосон)¹³

Өрхийн хэрэглээ

- Өрхийн гишүүдийн тоо
- Өрхийн тэргүүний хэн нь болох
- Өрхийн тэргүүний тодорхойлолт (гол тэжээгч, шийдвэр гаргагч, асран хамгаалагч г.м.)
- Гэр бүлийн гишүүн бүрийн нас, хүйс
- Гэр бүл дэх бүх гишүүдийн эцэг, эх, хамтран амьдрагчдыг тогтоох
- Гэр бүлийн байдал

Гэр бүл дэх 5 буюу түүнээс дээш насныханд зориулсан ганцаарчилсан хувьсагчид

- Бичиг үсгийн мэдлэг
- Сургуульд сурдаг эсэх
- Хэл (яс үндэс)

Гэр бүл дэх 8 болон түүнээс дээш насныханд зориулсан ганцаарчилсан хувьсагчид

- Ажмл эрхлэлт
- Ажил мэргэжил

Орлого

- Үндсэн ажлаас олдог нийт орлого
- Бусад нэмэлт орлого (тэтгэвэр, татаас, түрээс болон бусад)

Нийгмийн халамжийн тэтгэлэг, хөтөлбөрүүд

Шилжилт хөдөлгөн

- Сүүлийн 5 жилд бүрмөсөн шилжин суурьшсан гишүүдийн тоо
- Хаашаа шилжин суурьшсан болон тэднээс орж ирдэг мөнгө
- Сүүлийн 12 сарын доторх гэр бүлийн гишүүдийн түр зуурн шилжилт хөдөлгөөн (8 болон түүнээс дээш насныханд): очсон газар, гэртээ илгээсэн мөнгөн тусламж, эзгүй байсан хугацаа

Эрүүл мэнд

- Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, хамрах хүрээ
- Гэр бүлд тахир дутуу хүн байгаа эсэх, байгаа бол ямар

Орон байр

- Шал, хана, дээврийн материал,
- Өрөөний тоо (нийт өрөөний тоо болон унтлагын өрөөний тоо)
- Нийтийн үйлчилгээ (ус, цахилгаан)
- өмчлөл
- Өрхийн өмч хөрөнгийн эзэмшил (цахилгаан хэрэгсэл, машин, бусад)

Газар, мал

- Газрын тоо, хэмжээ
- Газрын ашиглалт (газар тариалан, ойн аж ахуй, мал аж ахуй)
- Услалт
- Мал, амьтны тоо, төрөл

¹³ Скоуфиас Е. ба бусад, “Прогреса дахь Хетеберт хамрагдах ерхүүдийг сонгох үйл явцын үнэлгээ”-нээс (“Prograsa: Mbs Oportunidades par las Familias Pobres”, Mexico, 2000.) иш татав.

Ном зүй

Сангийн яамны Ядуурлын судалгааны нэгж, НҮБХХ-өөс 2005 онд хамтран гаргасан “Өрх, иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг ижил хөгжилтэй бусад орныхтой харьцуулсан судалгаа”, 2005 он.

Скоуфиас Е. Ба бусад, “Прогреса дахь Хөтөбөрт хамрагдах өрхүүдийг сонгох үйл явцын үнэлгээ”, Мехико, 2000 он.

Дэлхийн банкны Зүүн Ази, Номхон далайн Хүний хөгжлийн асуудлаархи багаас эрхлэн гаргасан судалгааны ажлын цуврал

№. 2004-1: Зүүн Ази дахь тахир дутуу иргэдийн асуудлууд: Үнэлгээ ба хэтийн төлөв

№. 2004-2: Камбож улс: Чадвар ба өсөлт

№. 2004-3:SGP болон SIGP-ийн үнэлгээ: Одоо байгаа судалгааны ажлуудын үнэлгээ

№. 2004-4: Вьетнам: Унших болон Математикийн хичээлийн үнэлгээ: 1-р хэсэг

№. 2004-5: Хятадын хотууд дахь эрүүл мэндийн үйлчилгээн дэх тэгш бус байдлыг бууруулах: эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэл хийх туршилтын судалгаа

№. 2004-6: Зүүн Ази, Номхон далайн орнууд дахь дээд боловсролыг магадлан итгэлмжлэх, боловсролын чанарыг хангах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

№. 2004-8: Филипиний ядууст зориулсан эрүүл мэндийн үйлчилгээг санхүүжүүлэх

№. 2004-8: Вьетнам дахь ядууст зориулсан эрүүл мэндийн үйлчилгээг санхүүжүүлэх

№. 2004-9: Тайланд дахь ядууст ээлтэй эрүүл мэндийн санхүүжилтийн хөтөлбөрүүд: Улс орны туршлагын үнэлгээ

№. 2004-10: Индонези дэх ядууст зориулсан эрүүл мэндийн санхүүжилт

№. 2004-11: Хятадад тарилгын аюулгүй байдлыг хангах: Үүнд хэр их хөрөнгө зарцуулагдах ба хэн санхүүжүүлэх вэ?

№. 2004-13: Боловсролын салбар дахь хувийн секторын оролцоо: Дэлхийн банкнаас Зүүн Ази, Номхон далайн бүсэд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тойм, 1996-2002 он

№. 2004-14: Номхон далайн арлуудын хүний хөгжлийн ололтын одоогийн чиг хандлага, хэтийн төлөв

№. 2005-1: Хятад улс: Өндөр насны тэтгэвэрийн эрхзүйн хариуцлага, тэтгэврийн шинэчлэлийн хувилбарууд

№. 2005-2: Камбож: Номын тэнцвэртэй байдлыг хангах: Камбожид бага боловсролд зориулж буй өрхийн зарлага

№. 2005-3: Вьетнам Мэдлэгийн ертөнцөд багшлахад суралцах

№. 2005-4: Эрүүл мэндийн нийгмийн халамжийг шинэчлэх